



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

## **БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр, Мягмар гараг

|                                          |             |
|------------------------------------------|-------------|
| <b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>   | <b>1</b>    |
| <b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>        | <b>2-5</b>  |
| <b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b> | <b>5-50</b> |

---

|                                                                                                                                                                                                             |       |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------|
| 1.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мега төслүүдийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсох | 5-49  |
| 2“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл                                                                                                                                              | 49-50 |

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы  
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны  
04 дүгээр сарын 30-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 23 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 52.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 25 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: П.Ганзориг, Ц.Даваасүрэн, С.Лүндэг, Б.Пунсалмаа.

**Нэг.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мега төслүүдийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын мэдээллийг сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга Б.Тулга, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын дарга Л.Балчинлуvsан, мөн газрын Төслийн нэгдсэн удирдлага, мониторингийн хэлтсийн дарга Л.Бат-Эрдэнэ, Эдийн засгийн коридорын хэрэгжилт хариуцсан ажилтан С.Баатархүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Аж үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, мөн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай, Үйлдвэр, технологийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Нэмэхбаяр, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн “Эрдэнэс ҮТП” ХХК-ийн Үйлдвэрлэл, технологи, төсөл хэрэгжүүлэлтийн газрын менежер Г.Ганхуяг, “Мон-Атом” ХХК-ийн захирал Д.Далайжаргал, мөн компанийн Геологи, уул уурхайн албаны дарга С.Халиунаа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт Ж.Гантулга, ахлах шинжээч М.Мөнхбат, шинжээч Т.Ундрах, Мега төслүүд хариуцсан зохицуулагч Б.Мөнхтөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, мөн албаны референт Г.Баярмаа нар байлцав.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мега төслүүдийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Д.Жаргалсайхан, П.Мөнхтулга, Ж.Золжаргал, Г.Очирбат, Д.Энхтуяа, М.Бадамсүрэн, Д.Пүрэвдаваа, Л.Мөнхбаясгалан, Д.Батбаяр, Д.Үүрийнтуяа, Д.Бум-Очир, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга Б.Тулга, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын дарга Л.Балчинлуvsан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Аж үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, мөн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай, Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн “Эрдэнэс ҮТП” ХХК-ийн Үйлдвэрлэл, технологи, төсөл хэрэгжүүлэлтийн газрын менежер Г.Ганхуяг, “Мон-Атом” ХХК-ийн захирал Д.Далайжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга, М.Бадамсүрэн, С.Замира, Д.Үүрийнтуяа, Ж.Золжаргал, С.Ганбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мега төслүүдийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөрийн мэдээллийг сонсов.

*Уг асуудлыг 17 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, мөн албаны референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга С.Ганбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**С.Ганбаатар:** “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18

61.1 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, гишүүдэд М.Бадамсүрэн, П.Мөнхтулга, Л.Мөнхбаясгалан, С.Замира, Г.Очирбат, Б.Уянга, М.Энхцэцэг, Д.Энхтуяа нар орж ажиллахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 37 минут үргэлжилж, 25 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 84.0 хувийн ирцтэйгээр 18 цаг 02 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН  
ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2025 оны 04 дүгээр сарын 30-ний өдөр,  
Мягмар гараг Төрийн ордон “Их засаг” танхим 10 цаг 35 минут

**АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ**

## ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

---

**С.Ганбаатар:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг та бүхэнд танилцуулъя. Ингээд С.Ганбаатар 1 дүгээр тойрог ирсэн байна. Бадамсүрэн гишүүн 6 дугаар тойрог ирсэн байна, Бум-Очир гишүүн ирсэн байна, Жаргалсайхан гишүүн ирсэн байна 1 дүгээр тойрог, Золжаргал гишүүн ирсэн байна 9 дүгээр тойрог, Лувсанжамц гишүүн ирсэн байна, Мөнхтулга гишүүн ирсэн байна 1 дүгээр тойрог, Очирбат гишүүн ирсэн байна. Пүрэвдаваа гишүүн ирсэн байна, Тулга гишүүн ирсэн байна 5 дугаар тойрог, Уянга гишүүн ирсэн байна. Энхтуяа гишүүн ирсэн байна. Ингээд ирц 52.2 хувийн ирцтэйгээр өнөөдрийн 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Ингээд Байнгын хорооны хуралдаан эхэлсэнтэй холбогдуулаад хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Нэгдүгээрт Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мега төслүүдийн хэрэгжилтийн явцын талаарх Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд Гантөмөр сайдын мэдээллийг сонсоно.

Хоёрдугаарт, Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ ээ.

Ингээд хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Хэлэлцэх асуудалтай холбогдуулж санал байхгүй бол хэлэлцэх асуудалдаа орно.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудлын нэгд Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагаас гаргасан хүсэлтийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мега төслүүдийн хэрэгжилтийн явцын талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын мэдээллийг сонсоно.

Ингээд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Гантөмөр сайд Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Батхүү Эдийн засаг хөгжлийн яамны ТНБД ирсэн байна. Анар Тус яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга Анар, Энх-Амгалан Тус яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Энх-Амгалан, Балчинлуvsан тус яамны Хөгжлийн төслийн бодлого зохицуулалтын газрын дарга ирсэн байна. Бат-Эрдэнэ Тус яамны Хөгжлийн төслийн бодлого зохицуулалтын газрын Төслийн нэгдсэн удирдлага мониторингийн хэлтсийн дарга Бат-Эрдэнэ ирсэн байна, Баатархүү тус яамны Хөгжлийн төслийн бодлого зохицуулалтын газар эдийн засгийн коридор хариуцсан ажилтан ирсэн байна.

Ингээд ЗГХЭГ-аас Цолмон ЗГХЭГ-ын дэд дарга яаралтай дуудаарай. Энэ хариуцлагатай энэ Засгийн газрын энэ Улсын Их. Хурлын ганц урдаа барьж байгаа ажил шүү дээ. Үүнийг Байнгын хорооноос дэмжье. Ямар асуудал дээр нь шуурхайлах вэ л гэж уг нь хуралдаж байгаа юм байгаа юм шүү дээ. Баттөр ЗГХЭГ-ын Салбарын бодлого зохицуулалтын газрын Үндэсний хороо Төсөл хөтөлбөр

хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч. Баттөр ирээгүй байна. Гантулга Засгийн газрын хэрэг эрхлэх газрын ахлах референт Ж.Гантулга ирсэн байна. Мөнхбат ЗГХЭГ-ын ахлах шинжээч, Ундрах ЗГХЭГ-ын шинжээч, Мөнхтөр ЗГХЭГ-ын мега төслүүд хариуцсан зохицуулагч ирсэн байна.

Ингээд Аж үйлдвэр эрдэс баялгийн яамнаас Сүхбат тус яамны Аж үйлдвэрийн бодлогын газрын дарга ирсэн байна, Хишигдалай тус яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга ирсэн байна. Нэмэхбаяр Тус яамны Үйлдвэр технологийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга.

Зам, тээврийн яам С.Батболд ЗТЯ-ны ТНБД ирж байгаа юм байна. Итгэлт тус яамны Төмөр замын далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга ирсэн байна.

Эрчим хүчний яамнаас Энхтүвшин тус яамны Бодлого төлөвлөлтийн газрын Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга.

Төсөл хэрэгжүүлэх нэгж. Ганхуяг Эрдэнэс үйлдвэр технологийн парк ХХК-ын Үйлдвэрлэл, технологи төсөл хэрэгжүүлэлтийн газрын менежер ирсэн байна. Сугарсүрэн “Мон-Атом” ХХК-ийн Захиргаа удирдлагын албаны дарга. Сугарсүрэн төлөөлж ирсэн юм уу? Тийм ээ. Халиунаа Мон-Атом Геологи, уул уурхайн албаны дарга. Ингээд үндсэндээ ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон тогтоолын төсөлтэй холбогдуулан ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцууллаа.

Мэдээллийг эхлээд та бүхэнд танилцуулна аа. Мэдээллийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд Гантөмөр та бүхэнд танилцуулна аа.

**Л.Гантөмөр:** Эрхэм Аж үйлдвэрийн байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа. Хамтарсан Засгийн газраас өнгөрсөн хугацаанд мега төслүүдийг эрэмбэлж нэгдсэн ойлголтод хүрэх талаар хүчин чармайлт гаргаж ажилласан. Энэний үр дүнд өнөөдөр Эрдэнэбүрэнгийн УЦС-ын тусгайлсан зээлийн хэлэлцээрийг байгуулж чадлаа. Мөн Гашуун сухайт Ганц модны хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтыг урагшлуулж Улсын Их Хурал маань хэлэлцээрийг баталсан 5 сарын 14-нд бид ажлыг эхлүүлэхээр төлөвлөөд ажиллаж байна. Мөн Монголын газрын тос боловсруулах үйлдвэрийн нэмэлт зээлийн хэлэлцээрийг бүтээж энийг Их Хурал маань баталж өгсөн. Энэ ажил хэвийн үргэлжилж байна. Монгол Францын хамтарсан ураны төслийн хөрөнгө оруулалтын гэрээг Улсын Их Хурал баталсан гээд бидний тавьсан зорилтоосоо эхний үр дүнд хүрч байгаа гэдгийг та бүхэндээ илтгэе.

Өнөөдөр та бүхэнд 14 мега төслийн хэрэгжилтийн явцын талаар мэдээллийг дэлгэрэнгүй хүргэнэ ээ. Тэр слайд чинь энэ дээрээ гардаг юм уу? Төслүүдийн эдийн засагт болон нийгэмд үзүүлэх нөлөөлөл болон салбараар нь ангилалд авч үзэх юм бол эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчим хүчний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, экспортын хүчин чадлыг нэмэгдүүлэх, эрчим хүчний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх нийгмийн дэд бүтцийг сайжруулах гэсэн үндсэн 4 ангилалд бид нар авч үзэж байгаа. Экспортын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүд хил холболтын төслүүд хэрэгжсэнээр экспортын орлогыг бид нар 2 дахин нэмэгдүүлнэ ээ гэсэн ийм зорилттой. Тээврийн зардлыг бууруулах чиглэлтэй чадвал 50хувь бууруулна гэсэн ийм чиглэлийг барьж ажиллаж

байгаа. Евроазийг холбосон шинэ гарцыг бий болгоно. Цаашаагаа эдийн засгийн коридороо улам өргөжүүлнэ, чадавхыг нэмэгдүүлнэ ээ гэж байгаа юм.

Дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төслүүд хэрэгжсэнээр ган төмөрлөгийн үйлдвэрийн суурь түүхий эд, стратегийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл бий болно. Шатахуун дотоодын хэрэгцээний 50-аас 60 хувийг хангана. Нефть, химийн шинэ салбар технологийн дэвшил бий болох боломжтой болно гэж үзэж байгаа.

Эрчим хүчний нийлүүлэлт нэмэгдүүлэх төслүүд хэрэгжсэнээр уул уурхайн бүсийн эрчим хүчний хангамж тогтворжино. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд горимын тохируулгын эх үүсвэр бий болж жилд 45-аас 50 сая долларын импортын төлбөр хэмнэж хямд үнэ бүхий цэвэр эрчим хүчээр хэрэглэгчдээ хангана гэсэн ийм зорилготой байгаа.

Одоогоор хэрэгжиж эхэлсэн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам ачаа тээврийн шилжүүлэн ачих терминал тэр дундаа Гашуун сухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын төсөл газрын тос боловсруулах цогцолбор, ураны төсөл, Эрдэнэбүрэнгийн УЦС, нүүрс, химийн, кокс химийн цогцолбор төслийн хөх нүүрсний үйлдвэр зэрэг 5 төсөл өнөөдөр хөдөлчихсөн байна гэдгийг илэрхийлье.

Төсөл тус бүрийн голлох үзүүлэлтийг энд харуулж байгаа. Энэ материалыг бол ер нь гишүүдийн мэйл рүү бүгдэн рүү нь өгөх нь зөв байх гэж бодож байна. Дараагийн слайдад төслүүдийн хэрэгжилтийн явц болон хийгдэх ажлуудыг товч танилцуулаад явъя. БНЭУ-ын Засгийн газраас 2024 оны 11 сарын 26-ны өдөр нэмэлт санхүүжилт олгохоор шийдвэрлэснээ Монголын талд албан ёсоор мэдэгдэж 2 тал нэмэлт зээлийн хэлэлцээрийн төслийн гэрээний зүйл заалт тус бүрээр хэлэлцээ хийж 2025 оны 1 сарын 16-ны өдөр Монгол Улсын Сангийн яам БНЭУ-ын Экспорт импортын банк хооронд үзэглэсэн Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн бүтээн байгуулалтыг дэд бүтцийн дараалал барилга байгууламж тус бүрийн төвөгшил болон инженерчлэлийн ажилд зарцуулагдах хугацааг тооцсоны үндсэн дээр нийт 4 багц хэсэгт хуваан 2028 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна аа.

Мөн олборлолтын хэмжээг орд ашиглах төлөвлөгөөнд тусгагдсан жилд 1.5 сая тонн хэмжээнд хүргэх зорилгоор Монгол Улсад олборлож байгаа газрын тосны түүхий эдийг үйлдвэрлэлд нийлүүлэх асуудлыг бүгд БНХАУ-ын тал буюу өнөөдөр олборлолт хийж байгаа компаниудтай ярьж баталгаажуулахаар ажиллаж байгаа. Яг энэ дээр бол хийх ажил маш их байна аа.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 1 сарын 10-ны өдөр Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцсөн тухай 2 дугаар тогтоол баталж хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцсөнд тооцсон. Төслийн хувьд Бадрах Энержи ХХК нь Зөөвч овоо, Дулаан уулын ураны ордуудыг газрын доор уусган олборлох технологиор ашиглах ба хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг хангаж үндсэн үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг 2025 оны эхний хагасаас эхлүүлэх нарийвчилсан инженерийн зураг төсөл хийлгэнэ. Бүтээн байгуулалтыг цаг тухайд нь эхлүүлэхээр төлөвлөөд ажиллаж байна аа. Төслийн хөрөнгө оруулалтын гэрээний араас бусад дагалдах гэрээний ажил 60 хувьтай үргэлжилж байгаа. Үүнд хувьцаа эзэмшигчдийн гэрээ, орд ашиглах гэрээ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ батлуулах зэрэг гэрээнүүд барилгын ажил 10 хувьтай эхлээд



явж байгаа гэсэн мэдээлэл байна. Нийт авах шаардлагатай зөвшөөрлийн 20 орчим хувь бол авагдсан байна аа.

Энэ төслийн хувьд ТББ болон олон нийтэд уран олборлох технологийн талаар зөв мэдээллийг хүргүүлж ажиллах шаардлагатай гэж үзэж байгаа. Аюулгүй байдал технологийн их өндөр түвшинд ажиллах зүй ёсны шаардлага байна гэдгийг хэлье ээ. Эрдэнэбүрэнгийн 90мвт-ын УЦС-ын төслийн хувьд өнгөрсөн хугацаанд ашиглалтын далангийн суурийн ажил, кемпийн байр хүнд даацын автомашин өнгөрүүлэх гүүр, хоолой, кольцо, техник засварын цехийн талбай болон байгаль орчин, археологи, палеонтологийн хайгуулын хайгуул, судалгаанууд хийгдэж дуусаж байгаа.

Барилга угсралтын бэлтгэл ажлыг 75 хувьтай байна гэсэн ийм үзүүлэлттэй байна. Энэ онд БНХАУ-ын Эксим банкны 79.9 сая ам.доллар-ын санхүүжилтээр төслийн ерөнхий зураг боловсруулж Эрчим хүчний үндэсний төвөөр батлуулаад явж байгаа. Цаашид нарийвчилсан зураг төслийг үе шаттайгаар магадлан хий хийлгүүлснээр барилга угсралтын ажил график хугацаандаа явуулах нөхцөл бүрдэж байгаа юм аа. Төслийн хүрээнд булш, бунхан, нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор нөхөн төлбөрийн гүйцэтгэл болон гааль татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн асуудалд анхаарал хандуулан ажиллаж байгаа гэдгээ илэрхийлье ээ.

Нүүрс, хими, хими кокс, кокс хими цогцолбор төслийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар 2025 оны 1 сарын 14-ний өдрийн 20 дугаар тогтоолоор нүүрс перолизын үйлдвэрийн бүтээн байгуулалтыг 2025 оны 2 дугаар улиралд багтаан эхлүүлэх шийдвэрийг гаргасан. Эдийн засагт өндөр ач холбогдолтой хөх нүүрсний үйлдвэрийн эхний шатыг 2026 онд барьж ашиглалтад оруулахаар төлөвлөөд ажиллаж байгаа. Тус үйлдвэр ашиглалтад орсноор ач холбогдол нь бол мэдээж эхний ээлжид Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь бууруулах зорилттой. Дайвар бүтээгдэхүүнээр стратегийн бүтээгдэхүүн, эрчим хүч, химийн түүхий эд үйлдвэрлэх зорилготой. Төсөл хэрэгжсэнээр 850 мянган тонн хөх нүүрс 77 мянган тонн давирхай 880 сая квт эрчим хүч үйлдвэрлэх боломжтой болох юм аа. Тус үйлдвэрийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгө оруулалт 190 сая ам.доллар бөгөөд богино хугацаанд хэрэгжих боломжтой гэж үзэж Эрдэнэс Монгол нэгдлийн зүгээс санхүүжилтийг тодорхой хэмжээнд шийдвэрлээд ажиллаж эхэлсэн. Энэхүү төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөнө. Энэ оны 2 дугаар улиралд багтаан шийдвэрлэхээр ажиллаж байна аа.

Экспортын орлогыг нэмэгдүүлэх төмөр замын хил холболтын төслүүдийн талаар мэдээлэл өгөхөд Гашуун сухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн хувьд Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр зам нүүрсний худалдаа Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2025 оны 3 сарын 27-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэн соёрхон батлуулсан. Бүтээн байгуулалтын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Төрийн худалдан авах ажиллагааны дэргэд байгуулсан бөгөөд бүтээн байгуулалтын нээлтийн үйл ажиллагааг 5 сард багтаан зохион байгуулахаар ажиллаж байгаа.

Хил дамнасан төмөр замын гүүрэн байгууламж өргөн болон нарийн царигийн өртөө технологийн барилга байгууламж зэрэг нийт барилгын ажлыг гүйцэтгэх

хугацааг 22 сар гэж сүүлийн тооцоо гарсан байна. Энэхүү хэлэлцээрийг соёрхон баталсан тул Шивээхүрэн-Сэхээ болон Хангимандал боомтуудыг үе шаттай холбох баруун зүүн тэнхлэгийн төмөр замын төслүүд хэрэгжих нөхцөл бүрдэж байгаа. Шивээ хүрэн-Сэхээ боомтын хил дамнасан төмөр замыг барих төслийн хувьд ачилт буулгалтын чингэлэг терминалын талбайн барилга угсралт бусад бүтээн байгуулалт, дэд бүтцийн барилга угсралтын ажил бүрэн дууссан. Хангимандал боомтын хил дамнасан төмөр зам барих төслийн хувьд Ханги өртөөний 720 хүний 6 блок ажилчдын амрах байр, 350 хүний гал тогооны барилга баригдсан байгаа. Номгон өртөөний ажилчдын амрах байр барилга болон дохиолол төвлөрүүлэлт, хориглолын байгууламжийн угсралт, суурилуулалтын ажил, ажлын гүйцэтгэл бүрэн дууссан.

Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2024 оны хэлэлцээрт Хангимандал төмөр замын боомтыг нэмж тусгах техникийн шийдэл гаргах, зөвшилцөх, хил дамнасан төмөр замыг цогцоор нь барих ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна аа. Монгол Улсын төмөр замын сүлжээ болон төмөр замын боомтуудын экспортлох хүчин чадал болон эдгээр төслүүдийг хэрэгжсэнээр нэмэгдэх орлогын хэмжээ болон бүтээн байгуулалтын үеийн ажлын байрны тоог та бүхэн энэ слайдаас харж болно. Эхний ээлжид Гашуун сухайт-Ганцмод боомтын хил холболтын гэрээг тохирч албажуулсны дараагаар энэ ондоо багтаагаад дараагийн боомтуудын хөрөнгө оруулалт гэрээний нөхцөлийг тохиролцох ажлыг эхлүүлнэ ээ. Үе шаттайгаар явна гэж ойлгох хэрэгтэй байгаа.

Төсөл яригдаж эхэлснээс хойш хөрөнгө оруулалтын эх үүсвэр, ТЭЗҮ, зураг төсөл, хил холболтын цэгт тохирох хэлэлцээрийн төсөл гээд барилга угсралтын ажил байнгын ашиглалтад хүлээн авах хүртэлх цаглаврыг бид нар энэ тов тодорхой харж харуулж байгаа. Дарааллын хувьд төмөр замын хэлэлцээрт нэмэлт оруулах асуудлыг яаралтай шийдвэрлэж дараагийн хийгдэх алхмуудыг цаг алдалгүй эхлүүлэх хөрөнгө оруулалтын яриа хэлэлцээрийг эцэслэх шаардлага бол байна аа.

Дараагийн ээлжид хэрэгжихээр бэлтгэл ажил хангагдсан ТЭЗҮ боловсруулагч дууссан. Эгийн голын 310 мвт-ын УЦС Хэрлэн тоонот Орхон Онги ус дамжуулах хоолойг барих төсөл, Зэс боловсруулах цогцолбор, Гангийн цогцолбор, Тавантолгой 450мвт-ын ДЦС зэрэг 5 төсөл байна аа.

Төсөл тус бүрийн голлох үзүүлэлтийг та бүхэн энэ дэлгэц дээрээс харж болно. Дараагийн слайдад энэ төслүүдийн хэрэгжилтийн явц болон хийгдэх ажлуудыг товч танилцуулъя аа. Эгийн голын 310 мвт-ын УЦС төсөл дээр Оросын талтай зөвшилцөлд хүрч байгаа гэж бид дүгнэж байгаа. Эгийн голын УЦС төслийн Байгал нуур, Сэлэнгэ мөрөнд үзүүлж болзошгүй нөлөөллийг үнэлэх Орос Монголын хамтарсан шинжээчдийн багийн дүгнэлтийг 2026 оны эхний хагаст гаргахаар төлөвлөж байна. Тус ажлын хүрээнд Монгол Улс болон ОХУ-ын ШУА-уд хамтран Сэлэнгэ мөрний экологийн урсцыг хангасан ашиглалтын горимын хувилбарыг санал боловсруулах зорилгоор Эгийн голын УЦС төслийн Сэлэнгэ мөрний сав газрын экосистемд үзүүлэх өөрчлөлтийг тодорхойлох судалгааны ажлыг Монгол Оросын экспертийн ажлын хэсэг хамтран хийхээр төлөвлөсөн тохирсон.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 3 сарын 12-ны өдрийн хуралдаанаар Эгийн голын УЦС төслийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцсэн бөгөөд туслах боомтын ТЭЗҮ болон үндсэн ТЭЗҮ-ийн нэмэлт

судалгааны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн төрийн худалдан авах ажиллагааны газар 2025 оны 4 сарын 11-ний өдөр зарлаж 2025 оны 5 сарын 9-ний өдөр нээхээр байна аа. Төсөвт өртөг нь 1.5 тэрбум төгрөгөөр энэ зураг төслийн ажил хийгдэж байгаа. Санамж бичгийн хүрээнд байгуулагдсан Эгийн голын УЦС төслийн Байгаль нуур, Сэлэнгэ мөрөнд үзүүлж болзошгүй нөлөөллийг үнэлэх Орос Монголын хамтарсан шинжээчдийн багийн дүгнэлтийг 2026 оны эхний хагаст гаргахаар төлөвлөж байгаа бөгөөд хээрийн судалгааг 2025 онд эхлүүлэхээр ажиллаж байна аа.

Орхон, Онги, Хэрлэн тоонот ус дамжуулах хоолой барих төслийн хувьд хуурайшилт хүчтэй явагдаж байгаа бүс нутгийн гадаргын усыг ашиглан экосистемийг тэтгэх шар шороон шуурга багасгах зэрэг чухал ач холбогдолтой. Эхний ээлжид бэлтгэл ажил хангагдсан төслүүдээс Орхон голоос Онги голын урсац нэмэгдүүлэх замаар Улаан нуурыг сэргээж улмаар говийн бүсийн усны нөөцийг нэмэгдүүлж тус бүс нутгийн ундны усны хэрэгцээг хангах зорилго бүхий Орхон, Онги төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж барилгын ажлын зураг төсөл судалгаа тооцооллын ажил хийж гүйцэтгэсэн байдаг. Орхон, Онги төслийн ТЭЗҮ үр өгөөж ач холбогдлоор нь экологийн болон эдийн засгийн төсөл гэж 2 ангилан санхүүжилтийн схемийг боловсруулж байгаа.

Бид бэлэн байгаа ТЭЗҮ-д түшиглэж бүх төслийг хурдтай эхлүүлэх хилийн усны асуудалгүй дотооддоо шийдэж, хамгийн хурдан явуулах боломжит хэлбэрээр экологийн төслийг нь эхний ээлжид эхлүүлэхээр зорьж байна аа. Говийн гадаргын усны төслүүд болох Хэрлэн тооно Орхон, Онги төслүүдийн хэрэгжилтээс шалтгаалан говийн бүсийн ундны усны хангамж мөн үйлдвэрлэлд шаардлагатай усан хангамжийн эх үүсвэр шийдвэрлэгдэх тул тухайн төслүүдийн хэрэгжилтээс хамааран зарим төслүүдийн бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөх шаардлагатай байгаа гэдгийг хэлье ээ.

Зэс боловсруулах цогцолбор буюу зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийн төслийн хувьд Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших Эрдэнэт үйлдвэр технологийн паркийн хүрээнд хэрэгжинэ ээ. Өнөөдрийн байдлаар 70 орчим сая америк долларын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг төлөвлөсөн бөгөөд 65 орчим хувьтай хийгдэж байгаа гэсэн ийм мэдээлэлтэй байна. Зэсийн баяжмал хайлуулах үйлдвэрийн төмөр зам, авто зам, ус татуургын дэд бүтцийн бэлтгэл ажлууд бүрэн хангагдсан бөгөөд төслийн ерөнхий төлөвлөгөө дэд бүтцийн эх үүсвэрийн судалгаа боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.

Энэ оны 2 дугаар улиралд багтаан ерөнхий гүйцэтгэгч сонгон шалгаруулах ЕРС тендерийг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байгаа. 2025 онд 264 орчим сая ам.доллар-ын хөрөнгө оруулалт хийгдэхээр төлөвлөгдсөн бөгөөд хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх худалдан авалтыг нэг эх үүсвэрээр хийх болон эрх зүйн орчны шинэчлэл хийх зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлага байгаа.

Гангийн үйлдвэрлэлийн цогцолбор байгуулахад шаардлагатай газрын асуудлыг урьдчилсан судалгаагаар инженер геологи болон дэд бүтцийн нөхцөл байдал дээр үндэслэн шийдвэрлэж Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт харьцангуй давуу талтай гэж дүгнэн 6 мянган га газрыг тусгай хэрэгцээнд авах талаар шийдвэр хүлээгдэж байгаа. Төслийн техник технологийн шийдэл бүтээн байгуулалтын бэлэн байдал, санхүүжилтийн эх үүсвэрийн хувилбаруудыг судалж, металлургийн үйлдвэрлэл, ган бүтээгдэхүүний чиглэлээр хөрөнгө оруулалт татах

бэлтгэл ажлыг ханган ажиллаж байгаа. Төслийн хүрээнд хэрэгжих шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн ТЭЗҮ-ийг Эрдэнэт үйлдвэр технологийн парк компанийн инженер техникийн ажилчид боловсруулан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн боловсруулах үйлдвэрлэлийг өргөтгөсөн салбар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулаад байгаа.

Ган үйлдвэрлэлийн цогцолбор төслийн хөгжлийн төлөвлөгөөг Эрдэнэс үйлдвэр технологийн парк компанийн зүгээс боловсруулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны паркийн зөвлөлөөр хэлэлцүүлэхэд бэлэн болоод хүлээгдэж байна.

Хөрөнгө оруулалтын гэрээг ТЭЗҮ нарийвчилсан зураг төсөл, бүтээн байгуулалт, ашиглалт гэсэн концепцын хүрээнд байгуулахаар төлөвлөж байгаа юм байна. Тавантолгойн станцын хувьд төслийг эхлүүлэхэд шаардлагатай ТЭЗҮ тодотгол газар эзэмших эрх авах ус хангамжийн эх үүсвэр болон бусад холбогдох зөвшөөрөл зэрэг бэлтгэл ажил бүрэн дууссан байдаг. Төслийн барилга угсралт болон санхүүжүүлэх эх үүсвэрийг хамтатган ЕРС нэмэх нь F нөхцөлөөр тендерийн баримт бичиг боловсруулан зарласан боловч жил гаран хугацаанд шүүхийн маргаантай явсаар ирсэн бөгөөд дээд шатын байгууллагаас чиглэл авч бэлтгэл ажлыг хангаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хүлээгдэж байна гэсэн мэдээлэлтэй байгаа. Мега төслүүдийн хувьд хууль, эрх зүйн ялангуяа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон тендерийн маргааныг шийдвэрлэх чиглэлээр өөрчлөлт шинэчлэлт хийх шаардлага байна аа. Үйлдвэр технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийг 2022 онд баталснаас хойш эдгээр үйлдвэрүүдийн байршлыг тодорхой болгож хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүдийг нарийвчлан тогтоосон 14 мега төслийн 4 төсөл нь эдгээр үйлдвэр технологийн паркт хамаарах бөгөөд байршлын хувьд хойд төв болон говийн бүсүүдэд байна аа.

Дээр дурдсан гүн боловсруулах үйлдвэрүүдийн эрчим хүчний хэрэглээ болон бүс нутгийн эрчим хүчний үйлдвэрлэлийн ерөнхий дүр зургийг харуулбал импортын цахилгаан эрчим хүчний эзлэх хувь 22.3 хувьтай гарч байгаа. Мега төслүүдийн төлөвлөлтөд эхнээс нь ус, эрчим хүчний судалгаа, нөөцийн үнэлгээг нарийвчлан гаргах шаардлагатай бөгөөд эдгээр төслүүдийн дэд бүтцийн хөгжүүлэлт байнгын ашиглалтад орсны дараах өсөн нэмэгдэх хэрэглээ зэргийг тооцооноор төслүүдийн тогтвортой тасралтгүй үйл ажиллагааг хангахад чухал ач холбогдолтой байгаа юм аа.

Мөн тухайн бүс нутгийн онцлогт тохирсон холимог хангамжийг судалж эрчим хүчний эх үүсвэрийг төрөлжүүлж, найдвартай байдал, эдийн засгийн үр ашиг экологийн тогтвортой байдлыг хангах боломжтой болж байгаа. Эрээнцэв, Чойбалсан Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр замын алт цэвэршүүлэх үйлдвэр, сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэр ер нь энэ сэргээгдэх эрчим хүчин дээр бол ЭХЯ ойрын үед бол маш тодорхой сүүлийн үед гаргаж байгаа шийдвэрүүдээ Засгийн газрын хуралдаанд танилцуулна гэсэн ийм чиглэлтэй байгаа.

Мөн Эрээн цэв, Чойбалсан, Бичигтийн босоо тэнхлэгийн төмөр замыг бид нар төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх зорилттой байна. Яг алт цэвэршүүлэх үйлдвэрийн тухайд бол нарийвчилсан тооцоо судалгаа бол дахиад жоохон шаардлагатай байна гэж өнөөдөртөө үзэж байгаа. Тэгэхдээ энэн дээр бол жишээлбэл Монголбанк бол бидэнд бэлэн төсөл байна гэж ингэж хэлдэг.

Тийм учраас энэ дээр ингээд тодорхой шийдэл гараагүй 4 төсөл энүүгээр өнөөдөр одоогийн байдлаар 4 төсөл дээр эцсийн шийдлүүд гараагүй байгаа шүү. Энэ дотроос тэгэхдээ сэргээгдэх эрчим хүчний ажлууд ойрын үед Засгийн газар болоод Их Хуралд танилцуулагдаад ажил хэрэг болоод явна гэсэн ийм хүлээлттэй байна. Тэгээд бид бол энэ 4 жилийн хугацаанд 14 мега төслөө хэрэгжүүлнэ. Ер нь 15 дахь мега төслөөр бол ОХУ-аас БНХАУ руу хийн дамжуулах хоолойны төсөл бол аль аль талдаа. /минут дуусав/.

**С.Ганбаатар:** Гантөмөр сайдад микрофон нээж өгье.

**Л.Гантөмөр:** Мега төслүүдийн замын зураглал болон төлөвлөлтийг зөв тооцох нь төслийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ ээ. Хамтарсан Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаанд 14 мега төслийг бүгдийг нь хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа хэдий ч дараагийн ээлжид эхлүүлэх төслүүдийн хувьд Улсын Их Хурал болон Засгийн газрын түвшинд шийдвэрлэх шаардлагатай нэлээн олон асуудал байна.

Эдгээрээс би заримыг нь дурдъя гэж бодож байна. Улсын Их Хурлын зүгээс газрын тусгай хэрэгцээнд авах хайгуул судалгаа хийх нөхцөлийг бүрдүүлэх шаардлага байна. Зээлийн нөхцөл батлан даалтыг батлах тодорхой хуулиудын нэмэлт, өөрчлөлт шинээр өргөн барих хуулиуд гээд байна. Төслийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлан сонсох, Өрийн удирдлагын тухай хуулийн хязгаарлалттай байгаа зохицуулалт нэмэлт зээлийн эх үүсвэр гаргах шийдвэр гэх мэт асуудлууд дээр дэмжлэг шаардлагатай байгаа. Энэ дээр Засгийн газар ч гэсэн тодорхой нарийвчилсан судалгаануудыг хийж танилцуулах юм аа.

Өнөөдрийн байдлаар бидний хийчихсэн байгаа ТЭЗҮ, байгаль орчин, хөрөнгө оруулалтын судалгаа хийх, гадаад зээл, төслийн санхүүжилтийн механизмаар эх үүсвэр, хөрөнгө оруулалт татах, холбогдох хууль, журмын өөрчлөлт, гэрээний төслүүдийг боловсруулах, барилга угсралт төслийг хэрэгжүүлэх бүх шатын ажлыг үр дүнтэй зохион байгуулах, өрийн бүтэц, эрсдэл тооцох, хувилбарууд боловсруулах зэрэг асуудлуудыг яаралтай хийхэд анхаарч ажиллаж байгаа гэдгээ та бүхэндээ илэрхийлье ээ.

Тэгээд өнөөдрийн хуралдаанаараа Байнгын хорооноос ажлын хэсэг гаргаад ажлын хэсэг Их Хурлын ажлын хэсэг бол энэ дээр тодорхой лийд хийгээд ажиллаасай гэж хүсэж байгаа. Өнөөдөр бол энд тухайн төслүүдийг бичиг цааснаас нь эхлүүлээд судлаад явж байгаа яамдуудын газрын дарга нар ирсэн байна аа. Тэгээд та бүхний асуултад манай яамдууд хийж байгаа ажлынхаа түвшинд хариулахад бэлэн байна аа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Ганбаатар:** Гантөмөр сайдад баярлалаа.

Тэгээд Монголчууд бид чинь нэг юм ярьж сонин дээрээ соохолзоно гэдэг шиг шуугьж шуугьж байгаад л чимээгүй алга болчихдог. 10 их наядын төсөл гээд л нэг баахан шуугьсан. Одоо ярьдаг ч хүн байдаггүй болсон. 14 мега төсөл бас л сураг нь алдарч байгаа. Тэгээд араас нь ингээд нэхэл хатуутай дэмжиж тусалж



шаардлагатай бол хариуцлага тооцож хуулийн хэрэгжилтийг хяналт тавих гэдэг бол Их Хурлын үндсэн үүрэг.

Ингээд Аж үйлдвэрийн бодлогын байнгын хороо энэ утгаараа ажиллаж байгаа. Гантөмөр сайдын яам бол энэ дээр байдгаараа хичээж байгаа. Тэгэхдээ олон яам оролцож байгаа учраас бид араас нь ингээд дэмжиж хуулийн хэрэгжилтэд хяналт тавих утгаараа ингэж ажлын хэсэг байгуулж ажиллана аа. Гантөмөр сайдад баярлалаа.

Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Энхтуяа гишүүнээр тасаллаа. Батбаяр гишүүнээр Далайн Батбаяр гишүүнээр тасаллаа.

Ингээд Уянга гишүүн эхний асуултыг асууна аа.

**Б.Уянга:** Өнөөдөр 14 мега төслийн ерөнхий танилцуулгатай танилцаж байгаадаа баяртай байна. Төслүүдээ ерөнхийд нь багцлаад харах юм бол төмөр зам барих төсөл 2, кокс химийн 2, зэс боловсруулах 1, төмөрлөгийн үйлдвэр 1, алт цэвэршүүлэх 1. Ус дамжуулах хоолойн төсөл, ураны төсөл, газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл гээд. Ингээд тэгээд эрчим хүчний 4 төсөлтэй байгаа.

Тэгээд өөрийнхөө өнөөдөр Гантөмөр сайдаас асуух асуулт эрчим хүчний төслүүд рүүгээ чиглээсэй гэж бодож байна. Ер нь өнөөдөр Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороон дээр энэ төслүүдийг авч ирж ярилцаж байгаа нь хүртэл ер нь аливаа манай улсад явагдах гэж байгаа аж үйлдвэржилтийн санаачилга бүүр эрчим хүчнийхээ эх үүсвэр дээр очоод гацаад байгаа дүр зурагтай байдагтай холбоотой байх гэж боддог.

Тэгээд Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төсөл, Эгийн голын төсөл, Сэргээгдэх эрчим хүч, Тавантолгойн ДЦС гэдгээр 4 төслийг харахаар нийтлэг асуудал. Нэг цаг хугацааны л асуудал. Нэг их тийм яахаа бид нар яг мэдэхгүй байгаа юм шиг. Жишээ нь Эрдэнэбүрэнгийн усан цахилгааны төслийг болохоор 2018 онд Засгийн газраас тогтоол батлаад энэ УЦС-ыг барья гээд орсон байна. 2021 онд түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ байгуулаад 2023 онд болохоор 3 дугаар сард ажил гүйцэтгэх гэрээ байгуулаад 2025 онд үндсэн зураг төслүүдээ 7 жил дамнаад явж байгаа юм байна аа. Барилга угсралтын ажлыг хийнэ ээ гээд танилцуулга дээр гишүүдэд өгсөн танилцуулга дээр байгаа.

Эгийн голын усан цахилгаан станцын төсөл хэзээ эхэлсэн нь танилцуулга дээр ирээгүй. Миний л мэдэхийн их олон жил яваа. Тэгээд одоо бол Сэлэнгэ мөрний сав газрын эко системд үзүүлэх өөрчлөлтийг судлах Монгол, Оросын эрдэмтэд нэлээн судалгаа хийх гэж байгаа юм байна. Тэгээд өмнө нь хийгдэж байсан л юм шиг санагдах юм. 2026 онд үр дүн нь гарах юм байна. Сэргээгдэх эрчим хүчний энэ гишүүдэд танилцуулсан танилцуулга дээр болохоор салхин, наран гэж 2 хуваагаад нарны цахилгаан станцыг тархмал байдлаар зохион байгуулах боломжтой юм байна гэдэг дүгнэлтээ л ярьсан байна.

Тэгээд Тавантолгойн дулаан цахилгаан станц бол бүүр 2020 онд бүтээн байгуулалтыг эрчимжүүлье ээ гэсэн Засгийн газрын тогтоолтойгоор өнөөдөр хүрсэн байна аа. Тэгэхээр Гантөмөр сайд бүгдээрээ ер нь ийм эрчим хүчний төслүүдийг мега төсөл нэр доор ингээд том том төслүүдийг барьж явах нь оновчтой биш юм уу?

Жижиглэх ёстой юм болов уу? Хувийн хэвшил дээр тулгуурлаад явсан нь илүү онох байсан юм болов уу? Одоо ер нь яг яах вэ? Танай нэлээн сайн ажиллаж байгаа Засгийн газар хамтарсан байдлаар их олон зүйлүүдийг хурдан хугацаанд хөдөлгөлөө гэж харж байгаа. Эрчим хүчний төслүүдээ л эхлээд бариад авчихмаар байна. Энэ дээр таны төлөвлөгөө юу байгаа бол?

**С.Ганбаатар:** Гантөмөр сайд асуултад хариулъя.

**Л.Гантөмөр:** Тэгэхээр би түрүүн танилцуулгадаа их тодорхой хэлсэн.

Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцын санхүүжилтийн асуудал бол сая өнгөрсөн оны төгсгөлд шийдэгдсэн. Тэгээд бид нартай цуг их олон гишүүн Шанхайд очиж асуудлаа шийдсэн байгаа. Эгийн голын цахилгаан станц мэдээж хэрэг хийж байгаа судалгаа бол өнөөдрийн байдлаар энэ цахилгаан станцыг барина гэдэгт бол эргэлзэхгүйгээр алхаж байгаа. Тэгэхдээ энэ бол бас ОХУ-тайгаа ярьж шийдэх ийм ажил байгаа юм аа. Ярилцахаас өөр аргагүй юм байна лээ тэгээд ярилцаад явж байгаа. Огт хамаагүй гэж бид нар дураараа яримааргүй байгаа юм.

Тэгэхээр таны хэлж байгаа санаануудыг бид нар бүрэн хүлээж авч байгаа. Ер нь эрчим хүч шийдэгдэхгүйгээр үйлдвэрлэл шийдэгдэхгүй. Тавантолгой сэргээгдэх 2 бол цэвэр манай дотоодоос хамааралтай. Энэ дээр бол цэвэр ЭХЯ-ны үйл хэрэг эндээс шууд хамааралтай. Сэргээгдэх бол дандаа хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэнэ. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэхийн тулд бол эх үүсвэр, нөгөө хэнд, хэнээр юу хийлгэх вэ гэдэг асуудал дээрээ тулчихсан байгаа гэж би ойлгож байгаа. 3, 4 томоохон станцын төслийг одоогоор зарлаж байгаа. Зарлаж байна гэдэг нь үнэ хаялцуулаад хамгийн хямд үнийг санал болгодог, болгох болгосон. Тэр хөрөнгө оруулагч нарт бол яг сэргээгдэхийнхээ эрхийг өгөх юм байна аа.

Тийм учраас бол энэ дээр нэгдсэн мэдээллийг Чойжилсүрэн сайд ойрын үед Засгийн газар дээр танилцуулна гэсэн ийм чигтэй байгаа. Ер нь бид бол Тавантолгойн цахилгаан станцын тухайд бол 2 дугаар улиралд багтаагаад тодорхой шийдэл гаргахыг Чойжилсүрэн сайдад бол Засгийн газар чиглэл өгчхөөд одоо бол яг тэдний эрх хэмжээний хийх ажлууд хийгдээд явж байгаа гэдгийг хэлье.

**С.Ганбаатар:** Асуултад хариултаа авлаа. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууна аа.

**Д.Жаргалсайхан:** Энэ 14 мега төслийн танилцуулгыг сонслоо. Ажлын явц бол харьцангуй сайн явж байна. Ер нь бидний хувьд энэ төслүүдээ юу гэдэг юм ингээд л нэг шууд эхэлчихнэ гэж ингэж бодоод байх шиг байна. Үгүй л дээ энэ том төсөл маш их хэмжээний зураг төсөв, ТЭЗҮ, судалгаа, тэгээд хөрөнгө оруулалт тэгээд л ер нь л ер нь л нэлээн сайн судалж байж явахгүй бол буруу эхэлчихвэл тэгээд л эхнээсээ буруу болж хувирна. Тэр ч үүднээсээ бол энэ баг бол цаг хугацаанд тэр тусмаа нэг хэдэн холболтын төмөр замын гэрээ хийгдсэн ажил нь эхлэх шатдаа орчихсон явж байна гэдэг бол арван хэдэн жил хүлээсэн энэ ажил эхэлсэн байгаа нь бол сайн. Гэхдээ энэ төмөр зам дээр одоо ингээд энэ ажлыг бол эхэлчихсэн гэж үзнэ биз дээ Гантөмөр сайд аа.

Тэгэхээр дараагийн Шивээ хүрэн энэ Хангийн холболтуудыг хийх асуудлыг хийх ажилдаа бас ер нь юу гэдэг юм аль ч талдаа ер нь цаасны ажил гэдэг бол ер

нь л бараг 50 хувь шүү дээ. Тэгэхээр ийм ажлууд нь ингээд Улсын Их Хурал руу орж ирээд батлагдаад, гэрээ нь хүртэл батлагдаад гарчихсан байхад дараагийн ажлаа эхлүүлж байхад яагаад болохгүй байгаа юм бэ? Энэ дээр бас тодорхой санал санаачилга гаргаач ээ гэдэг нэг асуудал.

Хоёр дахь асуудал энэ Богд хаан төмөр зам гээд ажил эхэлж байна л даа. Тэгээд энэ үр ашгийн хувьд ямар юм бэ? Миний хувьд бол л тэр Эрээнцав ингээд Бичигтийн төмөр зам явах болов уу гэж ингэж харж байсан юм. Тэгээд энэ чинь мега төсөл дээрээ байгаад байгаа юм тиймээ. Гэтэл мега төсөл дээр байхгүй ажил ингэж орж ирж байгаа байхгүй юу. Тэгээд энэний санхүүжилт хаанаас явж байгаа юм. Ийм 2 асуудал байна.

**С.Ганбаатар:** Гантөмөр сайд асуултад хариулъя.

**Л.Гантөмөр:** Жаргалсайхан гишүүнтэй санал нэг байгаа. БНХАУ-ын Засгийн газартай бид нар хил холболт хийх дарааллаа бол олон жилийн өмнө тохирчихсон байдаг. Одоо яг энэ дарааллаар хийнэ ээ гээд. 1 дүгээрт Ганц мод-Гашуун сухайт, 2 дугаарт Бичигтийн боомт тэгээд Шивээ хүрэн, тэгээд Ханги Мандал. Шивээ хүрэн 2-т байгаа юм уу. Шивээ 2-т байгаа юм уу. Тэгэхээр бол яг энэ дарааллаараа явна аа. Бид 5 сарын 14-нд багтаагаад гүйцэтгэгч талтайгаа гэрээ хийхээр ажиллаж байгаа. Ганц мод-Гашуун сухайт дээр. Тэгээд энэ гэрээ хийгдээд ажил эхлэнгүүт магадгүй Их Хурал дээр дараагийн нөгөө Шивээ хүрэнгийнхээ асуудлыг хэдүүлээ ярилцана. Тэгээд бараг бэлэн байгаа. Тал талаас нь хөрөнгө оруулалт нь хийгдчихсэн. Би та бүхэнд түрүүн танилцуулсан. Энэ Богд хаан төмөр зам буюу Шинэ нисэхийн хөндий рүү явж байгаа төмөр замыг бол Монголын Төмөр зам компани барьж байгуулж байгаа. Барьж байгуулж байгаа. Энэ төмөр замын ач холбогдол бол ерөөсөө л Улаанбаатар хотын зүүн талаас орж ирсэн ачаа баруун тал руу нэвтрэх нэвтрэлтийг л бид нар хурдасгаж өгч байгаа юм. Одоо бол ирсэн ачаа бүгд Улаанбаатар хотын төвд бараг буугаад тэгээд цаашаагаа тээвэр бусад тээвэр лүү шилжиж байгаа. Энэ шилжилт өөрөө их ачаалалтай байна аа.

Тийм учраас бол бид нар энэ Улаанбаатараа тойрсон том тээврийн урсгалыг бий болгох ийм зорилготой хийгдэж байгаа ажил гэж ойлгож байгаа. Таны хэлж байгаа яг зүүн босоо руу бид нар зайлшгүй хөдлөх шаардлага байгаа. Зүүн босоо дээр бол нөгөө бичигт рүүгээ явдаг зам руугаа бол бид нар дараагийн Монголын төмөр зам компанийн дараагийн ажил болж орно. Энэ дээр бол концессын асуудал яригдана. Төр хувийн хэвшлийн түншлэлийн асуудал яригдана гэсэн ийм яриатай байна. Тэгэхдээ нөгөө талдаа босоо тэнхлэгийнх нь замыг зэрэг явуулах гэдэг ийм тооцоо судалгаа хийгээд ажиллаж байгаа гэдгийг хэлье.

**С.Ганбаатар:** Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асууя.

**Д.Жаргалсайхан:** Богд хаан төмөр замын тийм энэ Улаанбаатар хот мөн дээрээс энэ Айдсын даваа биш ээ юу билээ. Ингээд даваатай холбоотой тойрч байгаа энэ зам. Гэтэл энийг хурдасгаад өгсөн ч боомт дээр байгаа ачаалал бол өндөр байгаа шүү дээ. Замын-Үүд дээр гэсэн үг. Тэгэхээр энийгээ шийдээгүй байж энэ замыг хурдасгах шаардлага байгаа юм уу үгүй юу л гэдэг би асуулт асууж байгаа юм. Нэгд нь.

Хоёрт нь бол зүүн босоо буюу Бичигтийн Эрээнцав хоорондох энэ төмөр замыг явуулах нь бидний хувьд бол эдийн засгийн үр өгөөж нь их чухал байх болов



уу. Тэгээд энэ рүүгээ эхэлж хөрөнгө оруулалтаа хийх байсан юм биш үү? Яагаад ийм байдлыг алдчихав гэдэг нэг дэх асуудал.

Хоёрт нь хөрөнгө оруулалтын асуудал нь яаж шийдэгдэж байгаа вэ? Зүүн тал дээр. Бичигтийн чиглэлийн төмөр зам дээр. Миний ойлгож байгаагаар Богд хаан төмөр замыг бол 40 гаруй ААН-ийн нөгөө хамтарсан групп болсон байх тиймээ консорциум болсон. Тэндээс санхүүжилт гарна. Мөн дээрээс нь.

**С.Ганбаатар:** Гантөмөр сайд асуултад хариулъя. Тулга сайд хариулах юм байна.

**Б.Тулга:** Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг эрье ээ. Тэгэхээр төмөр замтай холбоотой асуулт дээр Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Энэ УБТЗ тэр Богд хаан төмөр замын цаашаа тавигдаж байгаа энэ сая нээлт хийсэн зам бол энэ Замын-Үүдээр Тяньжинаас ирж байгаа ачаа тээврийн асуудлыг шийдэх нэг ийм шийдэл байгаад байгаа юм. Тэгэхээр одоо байгаа энэ төмөр замаа ашиглаад Улаанбаатар хотод орж ирж бууж байгаа энэ логистикийн ачааллыг энэ урагшаагаа гаргаж байна л гэж ойлгох хэрэгтэй. Тэгэхгүй бол нөгөө Тяньжиний ачаалал гээд бид нар Замын-Үүд дээр ч юм уу бодоод байдаг. Яг үүн дээрээ Тяньжиний ачааллын үндсэн шалтгаан бол Улаанбаатар хотод байгаа. Улаанбаатар хот маань өөрөө нэг цуваа галт тэрэг нэг цуваа буюу 50-аас 100 чингэлэгтэй нэг цуваа галт тэрэг орж ирэхэд тэрийг буулгаад боловсруулдаг нэг чингэлэг тээврийн логистикийн тийм төв байхгүй байгаа.

Тийм учраас энэ төмөр замаар тэнд салаа төмөр зам бий болгож тээвэр логистикийн төвүүд рүү төвүүдээ тийшээ гаргах ийм зорилгын хүрээнд.

**С.Ганбаатар:** Буяагийн Тулга сайд нэмэлт минут өгье.

**Б.Тулга:** Улаанбаатартай холбоотой Богдын төмөр замтай холбоотой бол одоо ийм ажил энэ ондоо дуусахаар ингэж зорьж ажиллаж байгаа. Зүүн талын босоо бол хөрөнгө оруулалт хамаагүй их шаардана. Өмнө нь бол төр хувийн хэвшлийн концессын хуулийн дагуу бол бас ААН шалгаруулаад явж байсан. Харамсалтай нь концессын хууль хүчингүй болоод тэр хэлэлцээр бол хүчингүй болчихсон. Одоо төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар явах ёстой. Гэхдээ энэ хуулиар явахад бол асуудал байна гээд энийг засаж байж бид нар цаашаа явуулах ёстой. Шивээ хүрэн дээр нэмэлт юу өгөхөд бол Ганцмод-Гашуунсухайтын төмөр зам барилгын ажил эхлэхэд дараачийн төмөр замын холболт бол Шивээхүрэнгийн төмөр замаар явна. Одоогийн байдлаар Шивээхүрэн боомт дээр нарийн төмөр замын 10 сая тонн эрдэс баялгийн бүтээгдэхүүн боловсруулж чадах нарийн төмөр замын терминал төмөр замын өртөө бол ашиглалтад орсон байгаа. Хятадын талтай бол холбогдоогүй байгаа хилийн бүсэд. Энэ маань ажилд орохын тулд бол бид нар Их Хурал дээр тодорхой шийдвэрүүдийг гаргах ийм шаардлага байгаа. Тэгээд Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдоржийн санаачилсан.

**С.Ганбаатар:** Тулга сайдад нэмэлт нэг минут өгье.

**Б.Тулга:** Тэгэхээр энэ нөгөө хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар тохироод ингээд барьчихсан. Хятадын тал бол бас 2023 онд Монгол Улсын Ерөнхий сайд Хятадын Ерөнхий сайдтай уулзаж байх үед бол манай талаас тавьсан төмөр зам боомтын холболтууд дээр Хятадын тал онцгой анхаарал хандуулж байна гэж

Ерөнхий сайдын түвшинд хэлсэн 3 боомт байгаа. Энэний нэг нь бол Шивээ хүрэн, Сэхээ төмөр замын боомтын холболтоо яаравчилъя гэдэг энэ эрэмбийг бол Хятадын талаас Ерөнхий сайдын түвшинд тавьж байсан. Тийм учраас хамгийн хурдан холбоод ашиглалтад оруулах бололцоотой юу бол Шивээ хүрэн байгаа. Тэгээд дараа нь Бичигтээр ингээд явах ёстой.

Буяагийн Тулга сайдад баярлалаа. Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн асуулт асууна аа.

**П.Мөнхтулга:** Энэ өдрийн амрыг эрье ээ. 14 мега төслөөс 5-ын санхүүжилт шийдэгдсэн юм байна. Үлдсэн 9 нь тодорхойгүй байна аа. Мэдээжийн хэрэг үлдсэн 9 дээр улсын төсөв даахгүй. Урьд нь шийдэгдсэн 5-ыг харахлаар ихэнх нь Эксим банкны зээлээр явсан байна. Манай улс зээлжих эрх болон өрийн таазаа харахлаар үлдсэн 9 дээр дахиад Эксим банкны зээл ч гэдэг юм уу зээлийн асуудал яригдахад хэцүү болсон байна аа. Тэгэхээр бид нар үлдсэн 9-ийг явуулахын тулд хөрөнгө оруулагч нарт бид нар юу санал болгох юм бэ? Энэ санал болгох бараа бүтээгдэхүүн маань дэлхийн зах зээл дээр үнэтэй байгаа юу? Эрх зүйн боломж нь нээлттэй байгаа юу? Ер нь Эдийн засгийн хөгжлийн сайдын хувьд Байнгын хороонд хэлэх санал хүсэлт юу байна аа? Ингээд энэ асуултыг асууж байгаа юм.

Гуравт нь авто замын төсөл нэг ч харагдахгүй байгаа. Ер нь аливаа улсын ДНБ-ийг харах юм бол хөгжингүй орнуудад нэг 5-аас 10 хувь авто зам нөлөөлдөг ДНБ-д. Манайх шиг улсад бол маш өндөр. 15 хувь ДНБ-ийг авто зам эдийн засагт нөлөө үзүүлдэг өсгөдөг. Тэгтэл өнөөгийн байдал бол Монголд 6 хувьтай байгаа. ДНБ-д нөлөөлж байгаа манай хатуу хучилттай авто замын нөлөөлөл 6 хувьтай байгаа.

Тэгэхээр эдийн засгийн эргэлтийн нийт 90 хувь нь манайх авто замаар явж байгаа юм байна аа.

Энэ дээр 14 мега төсөл дээр Аж үйлдвэрийн байнгын хорооны зүгээс гишүүний хувьд энэ авто замын төслийг оруулах боломж бий юу? Энийг Байнгын хорооны даргад уламжилмаар байгаа юм. Эдийн засгийн сайдаас энэ авто замын төсөл дээр ямар бодолтой байна вэ гэсэн ийм асуудал байгаа юм. Статистик харахаар авто замд хөрөнгө оруулаагүйгээс болоод манай дотоодын бараа бүтээгдэхүүний эргэлтэд экспортын бараан дээр 30 хувь, импортын бараан дээр 40 хувийн нэмэгдэл үүсээд байна гэсэн ийм судалгаа өгөөд байна. Тэгэхээр бид нар энэ авто зам дээр төсөл хэрэгжүүлээгүйгээс болоод энэ 30-аас 40 хувийн үнийн өсөлт бол яваад байх юм байна гэсэн ийм тоон үзүүлэлт гарч байна аа. Тэгээд энэ 3 асуултад хариулт авъя аа.

**С.Ганбаатар:** Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Ер нь бидний хувьд бол ингээд цаг хугацаагаа олоод богинохон хугацаанд 5 төслийнхөө шийдлийг гаргаад 5 төслийн ард гарлаа гэдэг их том алхаж байгаа гэж би хувьдаа харж байгаа. Одоо бол таны хэлж байгаагаар дараагийн төслүүд яах вэ гээд. Тэгэхээр Шивээ хүрэн, Сэхээ, Ханги-Мандал гээд энэ 2 боомтын холболт бол өөрөө эдийн засгийн өгөөжтэй учраас яг хөрөнгө оруулалт нь орж ирнэ шийдэгдэнэ гэсэн ийм хүлээлттэй байгаа.

Нөгөө талдаа аж үйлдвэрийн хэдэн төсөл байна. Аж үйлдвэрийн төслүүд дээр бол гарцаа байхгүй зэс цэвэршүүлэх, зэс хайлах үйлдвэрийг бол Эрдэнэт үйлдвэр маань өөрөө лийд хийж явахаас өөр сонголтгүй. Гаднын хөрөнгө оруулагчийг авч орно. Гаднын хөрөнгө оруулагч гаднын тэр технологийн компанийнх нь оролцоог хэрхэн бий болгох вэ гэдэг энэ санхүүжилтийн зарчмаа ярилцаж байгаа ийм цаг үе байгаа. Эрчим хүчний төслүүд дээр бол ямар ч асуудалгүй хөрөнгө оруулагчид бэлэн байна. Хамгийн гол нь тэр хөрөнгө оруулагчдыг чөлөөтэй өрсөлдүүлэх тэр орчныг нь л бий болгоод өгчих юм бол эрчим хүчин дээр тэртээ тэрэнгүй хөрөнгөө оруулаад тодорхой хугацаанд ашгаа олоод гараад явах энэ эрчим хүчний төсөл хэрэгжүүлэх санхүүжүүлэгчид бол тийм хүн хайгаад яваад байхаар биш байна. Ялангуяа сэргээгдэх дээр бол эрт хөрөнгө оруулагчид бол их нааштай хандаж байгаа шүү гэдгийг хэлмээр байна.

Байнгын хороо маань бол ер нь энэ эрчим хүчний төслүүдийг эрүүл саруулаар явуулах тал дээр анхаарч өгөх юм бол дараа дараагийн төслүүд хэрэгжихэд түрүүний Уянгаа гишүүний хэлж байгаа энэ эрчим хүчийг нэг урагшлуулчихвал бусад нь яг дагаад хөдөлчих юм байна гэдэг ийм хүлээлт байна.

Тийм учраас бол эрчим хүчээ хэрхэн энэ жилийг ашиглаж хэрхэн гэрээнүүдээ хийх вэ? Ялангуяа Тавантолгойн цахилгаан станц. Нөгөөдөх нь бол сэргээгдэх гэсэн. Энэ 2 төсөл маань урагшаа явчих юм бол ер нь цаашаагаа нэлээн том алхчихаар байна. Тэгээд эрхэм гишүүний хэлж байгаа яг энэ авто замынхаа тухайд бид нар тухайлан хөрөнгө оруулалт татах бодлого гаргах юм биш үү гэдэгтэй би санал нэг байгаа. Энэ дээр одоо бид нар энэ төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулиа Их Хуралд нэмэлт, өөрчлөлт хийгээд өргөн барьж байгаа. Тэгээд өргөн баригдахаар та бүхэн маань энэ дээр бас яг төр хувийн хэвшил 2 хэрхэн түншлэх тухай дээр ингээд зөв ухааныг нь гаргаж өгөөч ээ гэж хүсмээр байгаа юм. Нэг бол хувийн хэвшил 100 хувь хариуцуулдаг. Эс бол төр 100 хувь хариуцдаг. Эс бол барьж өгөөд шууд мөнгөө авдаг гэдэг хэлбэрээс гадна тодорхой хөрөнгө оруулалтын хамтрагчид байх боломжуудын тухай тодорхой урт хугацаанд 20, 30 жилийн хугацаанд буцаагаад энэ нэг удаагийн бүтээн байгуулалтын төлбөрийг гаргах тухайд мөн тодорхой гэрээ хэлцлийн үр дүн дээр том төслүүдэд хөрөнгө оруулалт татах тухайд гэх мэтчилэн хэд хэдэн хувилбар яригдаж байна. Ялангуяа одоо энэ хөдөөгийн үйлдвэрүүдийг бий болгоход гарцаагүй төрөөс хөрөнгө оруулах шаардлага байна. Хөрөнгө оруулах.

Түүнээс төр тэр үйлдвэрийн эзэн байх шаардлага ерөөсөө алга. Хөрөнгө оруулаад тэрэн дээрээ Засгийн газар хувь эзэмшдэг. Тэрнийхээ ноогдол ашгийг нөгөө яг нийлүүлж байгаа малчид руугаа гаргадаг гэсэн ийм хэлбэрийг л бид нар чадвал энэ төр хувийн хэвшлийн түншлэлээр оруулчих юм бол манай бүс болгонд тодорхой ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлүүд бий болох нэг үгээр хэлбэл хөрөнгө оруулалтын тэр үнэ цэнийг нь Засгийн газар хуваалцдаг байх тэр боломжийн тухайд хэдүүлээ нэг шинэ гаргалгаа гаргах шаардлага байна гэж ингэж харж байна аа. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Мэдээлэл сонсохыг хүсэлт гаргасан Үүрийнтуяа гишүүнийг асуултын жагсаалтад оруулъя.

Очирбат гишүүнийг оруулъя. Ингээд Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууна.

**Ж.Золжаргал:** 2 асуулт байна аа. Эхний хэрэгжээд эхэлсэн 5 төсөл. Хил дамнасан төмөр замын байгууламж. Эрдэнэс Тавантолгой төлнө. Газрын тосны үйлдвэр Энэтхэгийн зээл, Уран Францын хөрөнгө оруулалт. Эрдэнэбүрэн Хятадын зээл.

Тав дахь нь болохоор нөгөө хөх нүүрс буюу хагас коксын үйлдвэр. Энэ төслийн санхүүжилтийг хаанаас хэдэн төгрөг ямар нөхцөлтэйгөөр авах гэж байгаа вэ? 1 дүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт нь одоо хэрэгжиж эхлээгүй байгаа бэлтгэлтэй байгаа төслүүд. 4 жилийн хугацаанд 14 төслөө хэрэгжүүлчихнэ. 15 дахь нь тэр болох байх гээд. 10 төсөл хэрэгжүүлнэ ээ. 10 төсөл хэрэгжүүлэхэд цаг үеийн байдлаас болоод нөгөө хамтарсан засаг байгуулагдаж байснаас хойш нэлээн юм өөрчлөгдчихлөө шүү дээ. Дэлхий даяар. Тэгээд мөнгө олдохгүй юм байна. Мөнгө олдохгүй болохоор бартердчихъя. Биржийнхээ хуулиар оруулж ирье гээд түрүүчийн 7 хоногт оруулж ирээд татаад авсан.

Тэгэхээр бартердчихаар тэр олон их наяд төгрөгийг бартердана гэдэг бол хөнгөлөлттэй, хямдруулсан үнээр өгнө гэсэн үг. Аль хэзээний хямдруулаад коксжих нүүрс бараг үлдэхээргүй том гэрээнүүдтэй болчихсон байгаа. Тэгээд нөгөө уурхайнууд нь дийлэх юм уу? Бартер гэдэг санаа ер нь хэдэн төгрөгийн ямар тооцоон дээр орж ирсэн юм.

Хэчнээн хэмжээний нүүрсийг хэдэн төсөл хэрэгжүүлэх эсвэл зэсийг юм уу тэр бартерын юм орж ирсэн юм. Энэ тал дээр Эдийн засаг хөгжлийн яаман дээр тоо байгаа юм уу. Санаа зовж байгаа зүйл бол том төслүүд яаж бид нар эдийн засгаа идэвхжүүлэх нь ээ гэдгийг ойлгож байгаа. Зөв байгаа. 5 төсөл ямар ч байсан 4 төсөл эхэлчихсэн. 5 дахь нь яригдаж байна.

Үлдсэн төслүүд чинь буцаад түүхий эдийн нь уначихсан дэлхий ертөнц сонин болчихсон эрсдэлтэй үед хамаг юмаа хөнгөлөлттэй үнээр өгөөд өрийн хавханд ороод эдийн засгаа чирч унагах гай болох юм биш биз дээ. Тэгэхээр энэ үлдсэн төслүүд дээр үр ашгийн болоод хөрөнгө оруулалтын ямар хувилбарууд байгаа юм бэ? Ийм 2 асуулт байна.

**С.Ганбаатар:** Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Ер нь бол мэдээж том бүтээн байгуулалтуудаа бол төсөв буюу тэгээд хөнгөлөлттэй зээл гэсэн хэлбэрээр өнөөдөр хүртэл манай Засгийн газар явуулж ирж байгаа. Тийм ээ Монголд сүүлийн 20, 30 жил бол энэний хажуугаар сүүлийн үед яригдаж байгаа нэг зүйл бол хөрөнгө оруулагчийг урих. Хөрөнгө оруулагчийг орж ирж тодорхой төсөл хэрэгжүүлэх тэр эрх зүйн орчныг хэрхэн зөв болгож хөрөнгө оруулалт татах вэ гэдэг ийм л бодлого хэрэгжүүлэхийг их удаан оролдож байгаа гэж би хувьдаа харж байгаа юм. Тийм учраас бид нар энэ төр хувийн хэвшлийн түншлэл гэдэг дээр тэр нэг хэсэг яваад эргэн төлөлттэй замын ачаалал өндөр болсон учраас шууд төлөөд бариад буцаагаад төлдөг гэдэг горимыг унтраасан. Одоо бол бариад ашиглаад буцааж төрд өгдөг гэдэг энэ горим руу шилжсэн. Энэ шилжилт дээр дахиад хэрвээ төсөвт ашигтай байна уу үгүй юу гэдэг ганцхан гаргалгаатайгаар энэ гэрээ яваад байгаа юм. Өнөөдөр хууль дээрээ.

Тэгэхээр төсөвт болоод бусад хэлбэрээр тухайн төсөл ашиггүй байх юм бол цаашаагаа явуулж болохгүй ээ гэсэн нэг ийм хандлага байгаад байгаа юм. Тэгэхээр бид нарын хувьд бол тэртээ тэргүй тавьж байгаа замаа маш урт хугацаанд эдийн засгийг дэмжинэ гэж тавьдаг. Тийм ээ тодорхой нийгмийн дэд бүтцийг урт удаан хугацаанд эдийн засгийг тэтгэнэ гэж хөрөнгө оруулдаг. Түүнээс биш одоо жишээлбэл Баянхонгор руу зам тавиад шууд ашиг өгнө өө гэж тооцоолоод л их төвөгтэй байдаг юм байна лээ.

Тийм учраас энэ хамтрах хэлбэр дээрээ хэдүүлээ нэлээн олон талаас нь юмаа харъя гэдэг байдлаар судалгаанууд хийгдээд, яамдуудаас саналаа аваад, ингээд нэгтгэгдээд ирж байгаа. Тэр солилцооны асуудал дээр бол зөвхөн Тавантолгойн нүүрсийн солилцоо гэж ерөөсөө ойлгохгүй байгаа. Бид нар Тавантолгойн нүүрсийг хямд үнээр өгөөд эдийн засагт хохиролтойгоор шийдчихсэн шийдэл бол байхгүй. Тогтвортойгоор нийлүүлэх гэрээний тухай л ярианууд өнөөдөр хүртэл өрнөж байгаа өрнөж байгаа.

Түүнээс биш тогтвортой нийлүүлэх үү эс бол богино богино хугацаанд худалдан авалт хийх үү гэдэг ийм 2 зүйл яригддаг. Үнэ өссөн үед бол богино хугацааны дийл нь Монгол талд ашигтай байдаг. Үнэ буурсан үед бол урт хугацааны гэрээгүйгээр бид өөрийнхөө орлогын бүрдүүлэлтийг тооцоолох боломжгүй болдог. Тийм учраас бол Тавантолгой дээр тодорхой хэмжээний урт хугацааны гэрээнүүд өнөөдөр хүртэл хийгдэж ирсэн юм билээ. Одоо бидний ярьж байгаа зүйл бол яг төд өд гэж өнөөдөр би тоо хэлэхэд хол байна. Тэгэхдээ маш тодорхой л асуудал шийдье гэж байгаа юм. Орон сууц. Тэрийг Их Хурал өөрөө хязгаарлаад өгчихмөөр юм байна лээ. Болсон болоогүй зам тавих биш. Орон сууцын асуудлыг энийгээ шийдэж болно. Тодорхой жишээлбэл Ордос аймагт юу болдог вэ гэхлээр машины үйлдвэр байгуулсан компанид жишээлбэл лиценз өгдөг 100 сая тонны нүүрс олборлох эрхийн лиценз. Юу гэсэн үг вэ гэвэл хэн нэг нь зүгээр ирээд уул уурхай ашиглаад гараад явдаг биш тухайн аймагт тухайн улсад ирээд хөрөнгө оруулалт хийгээд эдийн засагт нь ач холбогдолтой төсөл рискээ хүлээгээд хийсэн хүмүүст тодорхой тэр олборлох эрхийг нь өгдөг бусадтай адилхан татвараа авдаг ийм зүйл байгаад байгаа юм.

Жишээлбэл одоо баруун босоо дээр рискээ хүлээгээд оръё. Тэгэхдээ баруун босоог амилуулахын тулд бол ямар нэгэн бүтээгдэхүүнийг хойшоо урагшаагаа энэ замаар зөөх шаардлагатай. Зүүн босоо дээр. Энэ бүтээгдэхүүн олборлох асуудал дээр бидэнд боломж бий юу гэдэг ийм асуудал тавьж байгаа, хөрөнгө оруулагчид. Тэгэхээр тэр Сүхбаатар аймагт байна гэсэн үг шүү дээ. Дорнод аймагт байна л гэсэн үг. Тэрийг цаашаагаа гараад Владивостокоор гаргаад тэр Солонгосын зах зээл, Японы зах зээл, Энэтхэгийн зах зээл, мөн урагшаагаа аваад шууд Хятадын Тяньжиний арын боомтууд руу гаргах гэдэг ийм төслийг жишээ нь.

**С.Ганбаатар:** Жаргалсайханы Золжаргал гишүүн тодруулж асууя.

**Ж.Золжаргал:** Хагас коксын хөх нүүрсний төслийн хөрөнгө оруулалтыг яаж шийдэх нь тодорхой биш байгаа юм байна гэж ойлголоо. Би тэгвэл минутдаа багтаад дээр нь 2 юм хэлчихье. Энэ сая нөгөө агаарын бохирдлын сонсгол хийгээд тэгээд гишүүдийн байр суурь, нүүрстэй нүүрсэн түлш ямар нэгэн түлшинд татаас олгодог юмыг байхгүй болгоё. Иргэд өөрсдөө сонгодог больё хатуу түлшнээс ер нь татгалзах бодлого бариад хувилбаруудыг нь тавья гэдэг ийм зүйл маш дийлэнх нь яриад байгаа юм. Ажлын хэсэг дээрээ ядаж. Тэгэхээр энэнтэй яаж уялдуулж байгаа



юм бэ. Уялдахгүй явах юм уу? Бартер том юм яриад нүүрс зэс юу байдаг юм бүх юмаа тавиад сүүлдээ нөгөөх чинь том том төслийг хурдан хийнэ, хурдтай хөгжлийн төлөө зоригтой байя гээд бөөн хулгайны юм болоод сүүлдээ толгой нь олдохгүй юм холион бантан болох вий. Макро мега биш микро төслүүдээ хиймээр байна аа. Хүмүүсийн аж ахуй, тээвэр нийтийн.

**С.Ганбаатар:** Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Өнөөдөр хөх нүүрсний үйлдвэрлэлийн төсөл бол одоогийн байдлаар урьдчилсан үнэлгээгээр 100 сая ам.доллар-ын хөрөнгө оруулалт хийнэ ээ гэсэн ийм тооцоотой юм байна. Эрдэнэс үйлдвэр технологийн парк дээр энэ төслийн ажил явагдаж байна. Тэгэхээр бид нар бол өнөөдөр хүртэл яасан бэ гэхлээр яг ингэж мэргэн санаагаа уралдуулсаар байгаад л утаатай үлдсэн. Тийм учраас хэдүүлээ энэ удаа утааг хаая. Дахиад тоглоомгүй 2028 онд хэдүүлээ утаатай Улаанбаатарт очоод утааг чинь арилгая гээд яриад явж байх тийм эрүүл саруул хүн эндээс бараг төрөхгүй байх. Одоо бүгдээрээ ичиж эхэлж байгаа гэж би хувьдаа бодож байгаа. Шаардлагатай бүх арга хэмжээг л авъя гэж байгаа юм. Шаардлагатай бүх арга хэмжээг авъя. Энэ эдийн засгийг айхтар татаж унагах юм байхгүй ээ. Утаагүй болдог нь өөрөө 1-ээс 2 тэрбум долларын эдийн засгийн өгөөжийг авчрах юм байгаа юм. Өгөөж нь тэр. Тийм учраас утаагүй болох нь бол бид.

**С.Ганбаатар:** Гантөмөр сайд тодруулж хариулъя.

**Л.Гантөмөр:** Тийм байгаа юм аа. Тэгэхээр би бол яах вэ? Өнөөдөр Байнгын хорооны дарга 14 мега төслийн үйл явц хаана нь юу нь явж байна вэ? Тэрийг сонсьё гэж надад үүрэг өгсөн учраас би энэ хүрээндээ л өнөөдөр яримаар байна. Түүнээс биш ингээд Монголын асуудлыг хэдүүлээ тойрч суугаад бүгдийг нь дэлгээд ярих 1 дүгээрт хугацаа алга. Ярих ярих сэдвээ хэдүүлээ сонгоод цаг цагт нь яриад явсан нь дээр байх гэж ингэж бодож байгаа юм. Гишүүнд 100 сая доллар надад өгсөн өгч байгаа танилцуулга бол 2025 онд 40 сая доллар Эрдэнэс Монгол 49 хувийг нь оруулна. Хөрөнгө оруулагч 51 хувийг оруулах юм байна гэсэн ийм зураг байна. 2026 онд 60 сая ам.доллар Эрдэнэс Монгол 49 хувь. Хөрөнгө оруулагч 51 хувийн хөрөнгө оруулахаар. Тэгэхдээ энд бол магадгүй хөрөнгө оруулагч 70 хувь ч юм уу ингээд явж магадгүй байх. Эс бол Эрдэнэс Монгол 70 хувь ч юм уу ингээд явж магадгүй. Би бол эцсийн эцсийн шийдлийг нь бол энэ.

**С.Ганбаатар:** Ойлголоо. Гантөмөр сайдад баярлалаа. Ганбатын Очирбат гишүүн асуулт асууя.

**Г.Очирбат:** Өдрийн мэнд хүргэе ээ. Хамтарсан Засгийн газар бол хурдтай хөгжлийн төлөөх зориг гээд 14 мега төсөл. 2028 он гэхэд нэг хүнд ноогдох ДНБ-ийг 10 мянган долларт хүргэж эдийн засгийг 3 дахин тэлнэ гээд ингээд том зорилго дэвшүүлээд ажил руугаа орсон. Эхний 2, 3 төслүүд бол яваад амжилттай явж байна гэж харж байна аа. 14 мега төсөл гээд нэрэндээ нэг сүрдээд байгаа боловч тоогоор нь үзэх юм бол арван дөрөвхөн ажил.

Энэнээс нэг 4, 5 нь ингээд хөдлөх гээд байх шиг байна. Яах вэ би юм асуухгүй гэж бодсон. Тэгээд энэ танилцуулгатай холбоотой асуухаас өөр аргагүй болчихлоо. Бид нарт өгч байгаа энэ танилцуулга 14 мега төсөлд болохоор 25 онд энэ 5 төсөл үү л гэж байгаа юм. 2026 онд дахиад 5 төсөл, тэр 5 төсөл нь Тавантолгой 450 мегабайт дулааны ДЦС-ын гүйцэтгэл сонгон шалгаруулах гэж байгаа юм. Зэс



боловсруулах үйлдвэрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах гээд. Энэ 14 мега төсөл чинь 2028 он гэхэд эцсийн байдлаар бүгд ороод нөгөө нэг хүнд ноогдох ДНБ чинь 10 мянган долларт хүрчихсэн байх ёстой биз дээ. Тэгээд 2027 онд 2 ажлыг нь тавьчихсан. 2028 онд 2 ажлыг нь тавьчихсан.

Энэ чинь 2024 оноос эхлээд 14-үүлээ явж байх ёстой шүү дээ. Бичиг цаасны ажил нь дуусаад энэ чинь арван дөрөвхөн ажил. Мегал гээд нэрний ард яваад байгаа болохоос. 1 дүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал гэх юм бол энэ аль ч улс энэ эрчим хүчнийхээ асуудлыг эхэлж шийдэж байж аж үйлдвэрийн салбар бусад салбарууд нь явдаг аа. Дэд бүтцийнхээ асуудлыг шийдэх ёстой. Өнөөдөр 103 орчим Их Хурлын гишүүний гарын үсэг зуруулж байгаад ЭХЯ-ны сайд хариуцлагагүй байгаа. Зөвхөн эрчим хүчний үнийг нэмсэн. Ямар ч бодлогын өөрчлөлт хийхгүй байна. Гадна дотнын хөрөнгө оруулагч нар ялангуяа энэ бид нар ажлын хэсгээрээ энэ Германы ЭСЯ-ныхантай уулзсан. Тэгэхэд 3, 4 компани орж ирчхээд танай энэ хууль эрх зүйн тогтворгүй байдал энэ дүрэм журмыг чинь давж гарахгүй хөрөнгө оруулагч нар гараад явсан гэж байгаа юм. Тэгээд ямар эрх ашиг нуугдаад байдаг юм. Бөөрөлжүүт хот нийлж хийсэн. Одоо тэр нөгөө баян билүү, цахилгаан станц, ДЦС Чойжилсүрэн сайдын хамааралтай гэж яриад байгаа.

Хэрвээ ийм байвал ийм эрх ашгийн хамааралтай сайд энд байгаад энэ Монгол Улсын хөгжил цаашаа явах юм уу. Гантөмөр сайд энэн дээрээ та Тэргүүн шадар сайд бүх сайд нараа ингэж манлайлж ажиллаж байгаа. Доороо байгаа сайд нартаа энэ хамааралтай тэд нарыг нь болиулаад ажлаа урагшлуулахгүй бол энэ улс эх орны чинь хөгжил яг бодитой үнэнийг хэлэхэд явахааргүй харагдаад байна шүү 1-д.

Хоёрт гэх юм бол УБЕГ-аас мэдээлэл авахад 50 мянга орчим компани хаалга үүдээ барьчихсан байна. Тэгээд түрүүн та бас хэлж байх юм. Ер нь энэ төслүүддээ ингээд төр хөрөнгө оруулалт хийгээд явъя гэж. Тэгээд ер нь тодорхой хэмжээний юмаа аваад ингээд явъя гэж нэг ийм өгүүлбэр хэлчих юм. Тэгээд цаашдаа ингээд төр бүх юмаа аваад яваад байх юм уу?

**С.Ганбаатар:** Одоо нэмж авах юм уу? Очирбат гишүүнд гүйцээж асуух нэг минут өгье. Хувийн хэвшлээ дэмжээд явах юм уу. Энэ чинь ардчилсан Монгол Улс. Хувийн хэвшил байхгүй бол энэ татвар төлөгч нар чинь байхгүй болно. Энэ олон мянган компаниуд хаалгаа барьчихсан байж байхад манай засаг төр юу бодож байна аа.

Гурав дахь асуулт нь дахиад улсын төсөв тасарчихсан гэж яриад байна. Энийг одоо Тэргүүн шадар сайд маань ороод ирлээ яамдынхан ороод ирлээ. Бодитойгоор нэг хэлчихмээр байгаа юм. Хэдэн Их Хурлын гишүүд гарч ирээд ингээд дуугараад байдаг. Яг тасарчхаад байгаа юм уу, тасраагүй байдалд байгаад байгаа юм уу? Тодотгол хийх юм уу, хийхгүй юм уу? Эртхэн юмаа ярихгүй юм бол ингээд л улам л хэцүүдээд л эхэлнэ. Энд бас нэг тодорхой хариулт авчихмаар байгаад байна. Хамгийн сүүлийнх нь иргэд өөрсдөө эрчим хүч үйлдвэрлэе ээ гээд. Одоо гэр хороололд бодитой жишээ ярихад 380-д холбогдчихсон 220-д холбогдчихсон айлууд сэргээгдэх эрчим хүчээр өөртөө эрчим хүч үйлдвэрлээд илүүгээ төр рүү өгье өө гэхээр.

**С.Ганбаатар:** Гантөмөр сайд асуултад хариулъя.

**Л.Гантөмөр:** Эрхэм гишүүний асуултад хариулъя аа. Ер нь бол 14 мега төслийг 4 жилдээ хуваагаад тэгээд төгсгөл рүү нь зарим нь эхэлнэ гэж ойлгож болохгүй ээ гишүүн ээ. Бид нар өнөөдөр эхэлчихсэн. Яг бодитойгоор мөнгө нь ороод хөдлөөд эхэлж байгаа төслүүдээ 5 төсөл газар нь авагдаад ингээд асуудал нь шийдэгдчихсэн гэдгээ бол хэлж байгаа юм.

Дараагийн төслүүд бол энэ ондоо багтаагаад ч эхлэх юм байна. Дараа жил эхлэх юм байна. Түүнээс биш бүгдийг нь хуваарилж тавьчхаад энэ 5-ыг эхлүүлчихсэн. Үлдсэнийг нь дараа жил болъё гэж байгаа зүйл байхгүй шүү. Зүгээр явцын тухай мэдээлэл тэрэн дээр байгаа гэдгийг хэлмээр байна.

Нөгөө талдаа хэн нэгэн сайдыг ч юм уу хэн нэгэн даргыг хардаад хэрэггүй ээ. Энэ хамтарсан Засгийн газрын чинь ач холбогдол юу вэ гэхлээр харилцан хяналттай байгаад байна аа. Харилцан хяналттай учраас аль нэг хүн идсэн уусан асуудал бол ямар нэгэн байдлаар өнөөдөр хүртэл гарсангүй ээ. Би одоо бодит ажлуудыг нь хараад сууж байгаа хүний хувьд эрчим хүчний төслүүдийг албаар аль нэг сайд нь гацаагаад тэгээд өөр газарт өөр хүнд арын хаалгаар ямар нэгэн ажил өгч байгаа гэж ерөөсөө харахгүй байгаа. Гол юм бол Тавантолгойн нүүрсний уурхайн тендерийн маргааны л асуудал яваад байгаа юм. Бусдуудыг нь бол маш богино хугацаанд сэргээгдэх энэ төслүүдээ шалгаруулаад авчраад танилцуулна гээд Эрчим хүчний сайд маань хэлчихсэн байгаа. Нөгөө талдаа бол эрчим хүч, барилгын зөвшөөрөл, эрчим хүчний зөвшөөрөл гэсэн энэ асуудлууд дээр асар их хүнд суртал байгааг ойлгож байгаа.

Тийм учраас бол бид нар ирэх жил яг энэ бизнест тээг болж байгаа асуудлуудыг бүрэн шийдэх ийм он жил болгоно. Энэ ондоо багтаагаад бүх хууль эрх зүйн бэлтгэл ажлаа бүрэн хийнэ ээ гэсэн ийм төлөвлөгөөтэй Засгийн газар ажиллаж байгаа. Ингээд эхлэх юм бол хувийн хэвшлийн орон зай маш тодорхой болж эхэлнэ ээ.

Хувийн хэвшил рүү халддаг, хувийн хэвшлийн ажлыг ямар нэгэн дунд шатын дарга нь таслан зогсоодог. Эс бол тэнд ямар нэгэн төрийн албан хаагчийг аргадаж явах хэрэг гардаг ч гэдэг юм уу энэ асуудлууд бол их өөр болно гэдэгт бол би эргэлзэхгүй байгаа. Хаана яагаад яг хувийн хэвшил ажил хийх гэхлээр гацаад байна вэ гэдэг нь бол бид нар тодорхой судлаад гаргачихсан. Энэтэй холбоотой хуулиуд дээрээ сууж байгаа шүү гэдгийг эрхэм гишүүнд хэлье ээ.

Баярлалаа.

**С.Ганбаатар:** Ингээд Доржзодовын Энхтуяа гишүүн асуулт асууя.

**Д.Энхтуяа:** Эргэх холбоотой энэ 14 мега төслийн мэдээллийг өгч байгаа албаны хүмүүст талархаж байна аа. Ер нь Очирбат гишүүнтэй санал нэг байна. Бид нар яах вэ нэг жилийн өмнө энэ хурдтай хөгжлийн төлөөх Зориг гэсэн энэ хамтарсан Засгийн газрыг байгуулсан. Улсын Их Хурал дэмжсэн. Нэгэнт одоо ингээд дэмжээд энэ 14 мега төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын эдийн засаг хийгээд айл өрхийн амьдралд бодитой бас эдийн засгийн дэмжлэг хөгжил авчирна гэж ингэж хүлээж байгаа. Ийм ч хүлээлттэй учраас ер нь анхны дэмжиж явуулсан энэ санал дээрээ

бол миний хувьд, гишүүний хувьд бол дэмжээд үр дүнг нь харъя гэсэн ийм бодлоготой байгаа гэдгээ юун түрүүнд хэлье.

Олон асуудал давхцаж байгаа учраас энэ төслүүдийн санхүүжилтийн асуудлуудаар манай гишүүд тодорхой асуултуудыг асууж байна аа. Миний хувьд энэ Хэрлэн тооно төслийн талаар Орхон, Онги Хэрлэн тооно гэсэн энэ төслүүд бол ер нь бол энэ говийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа энэ уул уурхайн компаниудыг дэмжих мөн энэ говийн цөлжиж байгаа энэ экологийн байгаль экологийн асуудлуудыг шийдвэрлэхэд маш чухал төсөл өө гэж ингэж үзэж байгаа юм аа.

Тэгэхээр энэ төслүүдтэй холбоотойгоор энэ Хэрлэн тооно төслийг бол Оюу Толгойн санхүүжилт дээр санхүүжүүлнэ ээ гэсэн ийм танилцуулгыг өгч байсан санагдаж байна аа.

Тэгэхээр энэ төслийн санхүүжилтийн энэ бодит нөхцөл байдал ямар байгаа вэ? Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөөч ээ. Ер нь энэ санхүүжилтийг Оюу Толгой компани нийгмийн хариуцлагын хүрээнд энэ санхүүжүүлж байна уу эс үгүй бол суутган тооцох хэлбэрээр санхүүжүүлэх үү? Яг энэ дээр бол энэ санхүүжилт дээр бол ямар нэгэн мэдээлэл та бүхэнд байна уу? Энэ дээр нэг тодорхой мэдээлэл өгөөч ээ. Ингээд санхүүжүүлсний дараа ер нь энэ Засгийн газар ямар оролцоотой оролцох юм бэ? Гүйцэтгэлд нь энэ хувийн ААН-үүд мөн говийн бүсийн энэ дотоодын аж ахуйн компаниудаа оролцуулах тал дээр ямар төслийн санхүү хэлбэр явагдаж байгаа вэ гэсэн ийм асуудалд хариулт авъя.

**С.Ганбаатар:** Гантөмөр сайд асуултад хариулъя.

**Л.Гантөмөр:** Би түрүүн Очирбат гишүүний асуултад дутуу хариулсан байна уучлаарай. Яг өнөөдрийн байдлаар бид нар нэг 4 тэрбум долларын экспорттой байгаа. Өнгөрсөн жилтэй харьцуулахад нүүрсний үнэ 37, 38 хувиар унасан. Яг энэнтэй уялдаатайгаар 700 гаруй сая доллароор бага байна. Өнгөрсөн жилээс. Яг төсвийн төлбөрийн гүйцэтгэл дээр бол өнөөдрийн байдлаар ямар нэгэн байдлаар хүндрэл гараагүй байгаа. Бид энэ жил Монгол Улсын хэмжээнд 8.3 их наяд төгрөгийн санхүүжилт хийх төсөв баталсан. Энэ хөрөнгө оруулалтыг бол хийгээд явчих бүрэн бололцоо байгаа гэж харж байгаа.

Мэдээж төсвийн хуулиа өөрчлөхийн тулд алдагдал өөрөө тодорхой хэмжээнд очих ёстой. Ингэж байж төсвийн хууль өөрчлөгдөнө. Яг өнөөдөр бол санхүүжилт тасрахгүй байгаа учраас төсвийн хуулиа өөрчлөх төсөв тодотгох гэдэг яриа бол засаг дээр сонсогдохгүй байна гэдгийг хэлмээр байна. Нөгөө талдаа бид нар энэ жил дахиад энэ өнөөдөр дутуу явж байгаа энэ 700 сая доллар хэрхэн нөхөх вэ гэдэг төлөвлөлт хийгээд ажиллаж байгаа. Хэрхэн нөхөх вэ? Үлдсэн 7 сарын хугацаанд бид нар энийгээ нөхөж гүйцэх ёстой юм байгаа юм.

Тийм учраас бол нөгөө талынхаа гаралтыг л хурдасгах чиглэлээр яг миний хажууд жишээ нь Боомтын сайд маань сууж байна. Гаралтыг нь хурдасгах чиглэлээр ажиллаж байна аа. Энхтуяа гишүүний асуултад хариулъя. Хэрлэн тоонотын хувьд ТЭЗҮ-ийг Оюу Толгой компани хийж байгаа. Яг Хэрлэн тоонт төслийг хэрхэн явуулах вэ гэдэг эцсийн хувилбар эцсийн төлөвлөлт рүү бид нар орж чадахгүй байна аа. Энэ дээр бас нэг олон улсын усны тухай нэг асуудал үүссэн. Энийг бол бид нар шийдэхийн төлөө зүтгэнэ ээ. Өнөөдөртөө бол бид нар ер нь говийн бүсийн ундны

усны асуудлыг эхлээд шийдье ээ гэж ингэж зөвлөлд бид нэг хороо байгуулаад хороон дээрээ яриад шийдсэн. Тэр нь бол Орхон, Онги, Онги голоо сэргээе. Улаан нуурыг устай болгоё гэдэг төслийг энэ жил эхлүүлэхээр сая төслийн ажлын хэсгийг нь гаргаад ирэх 7 хоногийн хурлаар төслийн нэгж нь батлагдаад ингээд мөнгө санхүүгээ босгох ажил руугаа ороод явна. Энийг ингэж бид нар Улаан нуураа устай болгоод тэндээсээ Дундговийг яах вэ гэдэг асуудал яригдана гээд ингээд үе шаттай хийгээд явъя л гэсэн ийм төлөвлөлттэй байгаа шүү гишүүнээ.

**С.Ганбаатар:** Нэмж тодруулж асууя. Энхтуяа гишүүн тодруулж асууя.

**Д.Энхтуяа:** Уг нь энэ Хэрлэн тооно, Орхон Онги төсөл бол ер нь бол эхний ээлжид хэрэгжээсэй гэж ингэж хүсэж байна. Хэрэгжих юм маш олон асуудлуудыг шийдэх ийм төслүүд байгаа юм аа. Тэгэхээр ер нь бол нөгөө сая та санхүүжилтийн асуудал дээр жоохон дутуу хариулчих шиг боллоо. Оюу Толгой санхүүжүүлэх нь хэвээрээ юм уу? Энэ талаар ер нь яриа хэлцлүүд хийгдсэн үү? Тэгээд түрүүний асууснаар яг нийгмийн хариуцлагын хүрээнд хийж байна уу эс үгүй бол суутган тооцох хэлбэрээр явж байна уу эс үгүй бол буцалтгүй хэлбэрээр явж байна уу? Энэ дээр тодорхой ярилцсан зүйл байгаа юу? Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Тэгээд Хэрлэн тоонотын хувьд бол яг ТЭЗҮ-ийнх нь зардлыг бол Оюу Толгой нийгмийн чиглэлээрээ хийж байгаа хөрөнгө оруулалт гэж ойлгож болно. ТЭЗҮ гараад байгаль орчны үнэлгээ энэ тэр нь гарахаар хэрхэн мөнгөө шэйрлэх вэ гэдэг зүйл нь тусдаа яригдана. Яг өнөөдөр яриад 2 талд суугаад шийдчихсэн энэ зүйл Хэрлэн тоонот дээр алга байгаа.

**С.Ганбаатар:** Хариулт авлаа. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууна аа.

**М.Бадамсүрэн:** Баярлалаа. Энэ том төслүүдийн хэрэгжилтийн явцыг ингэж ер нь хагас жил тутам ч юм уу сонсох нь зөв л дөө. Тэгээд энэ бол ач холбогдолтой. Тэгээд ер нь би энэ том хэрэгжүүлж байгаа төслүүдийг харахдаа эдийн засгийн үр өгөөжөө өгөх энэ эргэж өөрөөр хэлбэл мөнгө олох ашиг тусаа өгөх энэ төслүүд рүү л үндсэндээ хөрөнгө оруулах зорилгыг агуулж байгаа л гэж ойлгож байгаа.

Тэгэхээр энэ бол хамгийн чухал. Тэгэхгүй бол бид нар эдийн засгийн үр өгөөж өгөхгүй зүйл дээр баахан хөрөнгө төсөвлөдөг. Тэгээд энэ маань эргээд бидний бодсон үр дүнд хүрэхгүй байх ийм эрсдэлтэй. Тэгэхээр мэдээж төр бол хувийн хэвшлийг, бизнесийг, зах зээлийг дэмжихдээ дэд бүтцээр л дэмжинэ. Тэр ойлгомжтой. Тэгэхээр энэ рүүгээ энэ чиглэх энэ үндсэн үзэл санаа санаагаа улам энийг бататгаж явах нь зүйтэй л гэж үзэж байгаа. Тэгээд энэ дээр 1 дүгээрт бол энэ зүүн босоо чиглэлийн төмөр замтай холбоотой энэ бол чухал. Ямар жишээ хэлэх гэж байна гэхээр ингээд үндсэндээ манайх 2 хөршийг холбосон транзит гэж хэлж болох ганцхан гол төмөр замтай. Энийг дагаад Монгол Улсын нийт хүн амын 70 хувь нь амьдардаг. Тэгээд ингээд Дархан, Улаанбаатар, Дорноговь гээд ингээд энэ төмөр замаа түшиглээд л үндсэндээ ингээд бараг л бүх аж үйлдвэрийн цогцолбор парк үйлдвэрүүдээ л барьж байгаа байхгүй юу. Тэгэхээр яг үүнтэй адилхан ингээд Зүүн, баруун босоо чиглэлд энэ төмөр замын төслүүд их том үр өгөөжөө өгөх учраас энэ дээр зүүн босоо чиглэлийн төмөр замыг ямар нэгэн аргаар одоо эхлүүлэх тал дээр Эдийн засгийн хөгжлийн сайдын хувьд онцгой анхаарч өгөөч ээ гэсэн хүсэлт байгаа юм.

Яагаад гэхээр аливаа ажлын эхлэл 50 хувь байдаг учраас энийг эхлэхгүй ингээд байгаад байвал нэлээн удаашрах байх аа. Энэ дээр нь хууль тогтоомжийн хувьд ямар боломж байгаа юм, ямар хөрөнгө оруулах ийм хувилбарууд байгаа юм гэдэг зүйлийг судлаад энийг даруй хэрэгжүүлж өгөөч ээ. Тэгвэл энэ төвлөрлийг сааруулах бүсчилсэн хөгжлийн хувьд нэг том бодлого болно. Энэ гол төмөр замд 70 хувь амьдарч байгаа бол энэ зүүн баруун босоо чиглэлийн төмөр замуудыг барьснаар тодорхой хэмжээнд ийшээ шилжилт явна энийг дагаж олон эерэг үр дүнгүүд гарна гэдгийг.

Хоёрдугаарт нь тэр усан хангамжийн төслүүдийн хувьд бол сайн ингэж гадаад дотоод талдаа хэлцэл энийг албан ёсны бүүр эрх бүхий байгууллага энэ орон нутгийн иргэд гээд энэ зүйл дээр зөвшилцөж яс тас болсны дараа эндээ үндсэн хөрөнгө оруулалтаа хийхгүй бол энэ маш их эрсдэл дагуулна шүү. Энэний жишээ бол энэ доод УЦС-уудын төслүүд байгаа.

Тэгэхээр энэ зүйл дээр мэдээж одоо өмнө нь гарсан энэ сургамжийг.

**С.Ганбаатар:** Асуулт асуусан биз дээ тэ. Гантөмөр сайд хариулах уу? Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Тэгэхээр Бадамсүрэн гишүүний саналтай бол санал нэг байгаа. Бид нар бол ганц төв коридороо хараад байдаг төв коридор нь өөрөө дамжуулах чадал их багатай. Тийм учраас бол баруун босоо, зүүн босоо, 2 бол гарцаагүй ажилд орох учиртай. Тэгээд хамгийн Монголд хамгийн хэрэгжиж болох нь бол зүүн босоо байна гэдэг зүйл их олон жил яригдсан. Тийм учраас бид нар бол энийг нээлттэй хэрхэн хөрөнгө оруулалт хийж хэрхэн гүйцэтгэж хэрхэн ашиглах тухайд тодорхой бодлогыг ондоо багтаагаад тодорхой шийдэлд хүрэхийн төлөө ажиллах болно гэдгийг хэлье. Усны асуудал дээр ч гэсэн би айхтар том дуугарахгүй байгаа нь бол бид говийн ард түмнээ ундны усаар хангах үүрэгтэй. Тэр үүргээ биелүүлэхийн тулд их няхуур үнэхээр орон нутгийнхаа иргэдтэй бүрэн ойлголцсон түвшинд урагшаа алхах шаардлага байгаа.

Тийм учраас би говийн гишүүддээ байнга хүсэж байгаа. Аль болохоор пи аргүйгээр тэгээд тэр ард түмэн ундны устай болох нь л чухал байна гэдэг зүйл. Тэгээд говийн гишүүд ч гэсэн энэ дээр их тийм нухацтай хандаж байгаа. Ямар ч байсан ажлын ард гар гэдэг ийм зүйлийг бол байнга хэлж байгаа. Тийм учраас таны хэлж байгаатай санал нэг байна аа. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууя.

**Д.Пүрэвдаваа:** Энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Тарааж өгсөн материалтай танилцаад хэд хэдэн асуудал байна.

Нэгдүгээрт экспортын орлогыг 2 дахин нэмнэ ээ гэсэн байгаа. Дээрээс нь импортын зардлыг 55 сая доллароор хэмнэнэ ээ гээд эдгээр тооцооллын бодвол яам нь гаргасан байх тийм үү. Тэгээд энийг яг нэг ийм тунхгийн шинжтэй 2 дахин, 55 эд нар гээд яг ингээд хатуугаар ингээд тооцож гаргаж байгаа нь иргэдийн эргэлзээг төрүүлээд байна. Энийгээ маш товчхон тэгээд тооцооллыг танилцуулаад бичгээр өгөөч ээ гэж хүсэх байна.



Хоёрдугаарт 38 мянган ажлын байр бий болно гээд. 38 мянган төрийн албан хаагч бий болж байгаа юм уу? Хувьд бий болж байгаа юм уу? Өнгөрсөн хугацаанд 3 нам хамтраад 30 мянгаар төрийн албан хаагчдаа л нэмсэн. Тэгээд тайлбар нь аягүй гоё. Юу вэ гэхээр зэрэг бид нар энэ төрийн албаны шалгалтыг давж чадахгүй энэ мундаг гадаад дотоодод төгссөн мэргэжилтнүүдээ шууд төрд орох боломжийг нь хангаж байгаа юм гээд иймэрхүү тайлбар хэлж байсан. Тийм учраас ард түмэн эргэлзэх эрхтэй учраас энийг болж өгвөл энэ сайд биш, энэ ажлын хэсгийн нэг бичиж орж ирсэн хүн би алдаа гаргачихсан байж магадгүй гэж хардаж байна. Тэгээд энэ экспортын орлоготой уялдуулаад сайдаас нэг асуулт байна. 9 мянга гарвал шаталсан хэлбэрээр бид нар АМНАТ авах ёстой хуультай. 11 хувийн АМНАТ гэдэг бол бага биш ээ. Бид нарт борлуулалтын орлогоос 5 хувийг авч байгаа. Оюу Толгой дээр бол тогтворжуулалтын гэрээ хийгээд тийм ээ 5 тэрбум доллар гэж бодоход 11 хувь гэдэг бол 550 сая доллар.

Бид нар энийгээ авахгүй гэдэг гэрээтэй. Авахгүй байж болно. Бусад Монгол Улсын зэсийн баяжмал борлуулж байгаа компаниуд өнөөдөр энийгээ төлж байгаа юу? Энэн дээр эдийн засгийн бодлого ямар байгаа вэ? Маш тодорхой хариулт авмаар байна. Тэгээд дараагийнх нь зүйл юу вэ гэхээр зэрэг төмөр замын Эрэн цав, Чойбалсан Бичигт төмөр зам гэдэг төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдсэн үү? Энэ дээр хийгдээгүй гэсэн байна. Хэзээ яаж хийчхэв. Энийг хийсэн юм уу, үгүй юм уу яаж хийсэн юм бэ?

Дээрээс нь гангийн цогцолбор Дархан хот 700 сая ам.доллар аравхан хувийг нь шийдсэн. Гадаадын хөрөнгө оруулалтын гэрээ хийгдээгүй. Энэ бол асуудал тийм үү? Энийгээ яаж тайлбарлах юм бэ? Тэгээд хамгийн сүүлд нь анх энэ Их Хурлаар орж байхад чинь нөгөө Богд уулын нүхлэх төсөл. 14 мега.

**С.Ганбаатар:** Аж үйлдвэрийн яамнаас Сүхбат дарга хариулах юм байна 5 номерын микрофоныг нээж өгье. 5 номерын микрофон.

**С.Сүхбат:** Гангийн зогсолт дээр байхгүй. АМНАТ надад байхгүй байна. Сангийн яамтай л холбогдох байх даа.

**С.Ганбаатар:** Ашигт малтмалын тухай хууль дээр байгаа. Та цээжээрээ мэдэх ёстой л гэж Пүрэвдаваа гишүүн хэлж байна. Би микрофон ашигладаг давуу талаа ашиглаад хэлчихье. 47 дугаар зүйл гэж ярьж байна.

**С.Сүхбат:** Тодруулж байгаад би хариу өгье өө.

**С.Ганбаатар:** Наадах чинь ч нохой үг дээ. Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Яг өсөн нэмэгдэх АМНАТ бол яг тэр хуваарийнхаа дагуу л авагдана шүү дээ. Өнөөдөр зэс экспортолж байгаа 2 компани байна. Нэг нь Эрдэнэт үйлдвэр байна нөгөөдөх нь Оюу Толгой компани байна. Эрдэнэт үйлдвэр бол АМНАТ-аа яг хуулийнхаа дагуу л төлөөд явдаг. Энүүгээрээ л төлнө. Тэрэн дээр бол ямар ч хөдөлгөөн гэх юм уу хэмнэлт байхгүй. Ер нь АМНАТ-ын нийт төлбөрийн хэмжээ энэ жил жоохон буурч гарна. Одоогийн байдлаар. Яагаад гэвэл нөгөө нүүрснийх нь үнэ буучихсан учраас энийгээ дагаад яг тэр хэмжээ нь бол бууж орж ирж байгаа гэдгийг хэлмээр байна. Ер нь 14 мега төсөл бол яаж сонгогдсон бэ гэдгийг та бид нар сайн мэдэж байгаа. Улс төржсөнөөс болоод явдаггүй



асуудлуудаа нэг улс төржихгүйгээр аж ахуйн ажил гэж үзээд шийдчихье ээ л гэж байгаа юм.

Энийг шийдчих юм бол Монголын эдийн засаг бол нэг хэмнэл рүүгээ орчихно оо. Тэр бид нарын яриад байдаг нэг хүнд оногдож байгаа ДНБ чинь 10 мянган долларт хүрчих юм байна аа. Их энгийн тооцоотой. Пүрэвдаваа гишүүний хэлж байгаа нь тэр нарийн тооцооллынх нь яг тооцоолсон программынх нь дагуу хийж чадаж байгаа бүтээлийнх нь дагуу танд хүргүүлье ээ.

Тэгэхээр бол асуудалгүй тэндээс хараад тодорхой ойлголтуудыг авчихна гэдэгт бол эргэлзэхгүй байна.

**С.Ганбаатар:** Нэмж тодруулж асуух юм уу? Асуусан асуултуудаа гүйцэд авъя гэнэ ээ. 8 номерт микрофоныг нээж өгье. Дарханы нөгөө 10 хувь 700 сая долларын хөрөнгө оруулалт.

**Х.Итгэлт:** ЗТЯ-ны Төмөр замын газрын дарга Итгэлт Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Зүүн босоо чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг 2011 онд Непон Кой компаниар хийлгэсэн иж бүрэн ТЭЗҮ бид нарт байгаа. Энэ ТЭЗҮ-ийг 2024 оны 10 дугаар сараас авхуулаад Монголын төмөр зам компани бол англи хэл дээрээс Монгол хэл рүү орчуулаад тэгээд шаардлагатай тооцоолол судалгааг бид хэд хийгдэж байна. Энэ дээр бол байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, эдийн засгийн тооцоо судалгаа, тэгээд энэ газрын асуудлуудыг бол дахиж судалж байгаа.

**С.Ганбаатар:** 8 номерт нэмж хариулах боломж өгье.

**Х.Итгэлт:** 2011 онд Нипан кой гэж компаниар иж бүрэн ТЭЗҮ хийгдсэн. Энэ дотор байгаль орчны үнийн нөлөөллийн үнэлгээ хийгдсэн байгаа.

**С.Ганбаатар:** Тэр нэг номерын микрофон дээр нээж өгье.

**Г.Ганхуяг:** Сайн байцгаана уу? Гишүүдэд энэ өдрийн амгаланг айлтгая. Эрдэнэс ҮТП компанийн төсөл хөгжүүлэлтийн газрын менежер Ганхуяг. Гангийн цогцолбортой холбоотой Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 2 сарын 5-ны өдөр 64 тоот тогтоол гарсан. Ингээд Дархан-Уул аймгийн Хонгор суманд гангийн цогцолбор байгуулахаар тогтоол гарсан байгаа. Мөн сүүлд энэ 3 сарын 28-нд Ерөнхий сайдын захирамжаар яг энэ гангийн үйлдвэртэй холбоотой ажлын хэсэг байгуулагдсан Учрал сайдаар ахлуулаад. Одоо бол гангийн төслийн явц бол өөрөө нийтдээ 650 орчим сая долларын хөрөнгө оруулалт гэсэн байна лээ. Урьдчилсан тооцоолол явж байгаа. Энэ дээр 30 орчим хувь дээр нь Эрдэнэс Монгол хөрөнгө оруулалтаа гаргах, 70 орчим хувь дээр нь хөрөнгө оруулагч оруулах гэсэн ийм хувилбартай боломжит хөрөнгө оруулагч нартай ажиллаад явж байна. Эрдэнэс Монгол нэгдлийн зүгээс 3 сард Гадаад хэргийн яамаар дамжуулаад дэлхийн нэг 40 орчим гангийн үйлдвэрүүдтэй топ гангийн үйлдвэрүүдэд нэг төсөл дээр хөрөнгө оруулагч оруулаач гэдэг саналыг хүргүүлсэн. Одоогийн байдлаар бол 8 компаниас хариу ирсэн байгаа. Эдгээрээс нь 7 компани нь Хятадын компани, нэг компани нь.

**С.Ганбаатар:** Пүрэвдаваа гишүүн гүйцээж тодруулж асууя.

**Д.Пүрэвдаваа:** Түрүүний нөгөө 38 мянган ажлын байрны яг мэдээлэл алга байна тодруулъя. Тэгээд энэ тарааж байгаа материал дээрээ жишээлбэл ураны

асуудал 100 хувь болчихсон гэсэн мөртөөсөө дэд бүтэц нь тэг хувьтай гэдэг мэдээлэл өгсөн байна аа. Тэгэхээр энэ бичиг цаасан дээрээ жоохон анхаарч ажиллавал яасан юм бэ гэж хэлмээр байна. Тэгээд хамгийн сүүлд энэ зэсийн үнэ чинь дээд оргилдоо хүрчээд байгаа байхгүй юу. 9400 баяжмал. Алт нэг хил нь 360 сая, 100 мянган доллар хүрчихсэн. Тэгээд эдийн засгийн хувьд манай нүүрс маань тодорхой хэмжээгээр, тодорхой хугацаанд хэмжээ нь ч тэр үнэ нь ч буурчхаад байгаа тохиолдолд одоо энэ алт хөтөлбөр болон дээрээс нь одоо бид нар ганц явж байгаа Эрдэнэт үйлдвэрээ Оюу Толгойгоос авч чадахгүй бол мөн Эрдэнэтээс авахгүй байх ёстой шүү дээ. Хэн хариулах юм. Хэнээс асууж байгаа юм.

Гантөмөр сайд тодруулж хариулья.

**Л.Гантөмөр:** Ер нь энэ 14 мега төслийг тойроод ямар нэгэн байдлаар төрийн албан хаагчид бол бодлого судалгаан дээр л ажлаа хийж байгаа шүү дээ. Тэрнээс цаашыг нь бол компаниуд гүйцэтгээд явна гэдгийг бүгдээрээ мэдэж байгаа. Газар шорооны ажил, бүтээн байгуулалтын ажил, гагнуурын ажил, тээврийн ажил гээд л. Ингээд л бүх л ажлыг хувийн хэвшил ороод л хийнэ шүү дээ. Яг энэ хүрээнд 38 мянган хүн шинээр ажиллах юм байна гэж харагдаж байгаа юм.

**С.Ганбаатар:** Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

**Л.Мөнхбаясгалан:** Говиос сонгогдсон гишүүн энэ 14 мега төслийн Франц, Монголын ураны төсөл, Хэрлэн тооно, Орхон Онги Тавантолгойн ДЦС газрын тос боловсруулах үйлдвэр, Тавантолгойн кокс, химийн үйлдвэр эд нар гээд 5, 6 нь манай говийн бүсэд хэрэгжинэ ээ. Гэтэл бид нарт говийн бүсэд хамгийн чухал хэрэгтэй юм бол ус. Говийн бүсээс маш их ашигт малтмал гадагшаа экспортолж байгаа улсаа тэжээдэг гол нэрийн бүтээгдэхүүнүүдээ экспортолдог. Тэгээд говийн гүний усаар тэрийгээ баяжуулж угаадаг. Гэтэл усны төсөл явахгүй байгаа нь надад маш тийм гунигтай харамсалтай санагдаж байна. Яагаад гэвэл энэ 14 мега төслийн хамгийн чухал төсөл нь бол энэ усны төсөл гэж боддог. Монголчуудад ч тийм. Аль аль бүс нь хоорондоо интеграцад орчихсон хангайн бүсийн гишүүдтэй, зүүн бүсийн гишүүдтэй бид ярилцаад ойлголцох ямар ч асуудал байхгүй. Гэтэл өнөөдөр энэ Орхон Онги төсөл дээр хилийн усны хэлэлцээр хийнэ тэр нь 5 хувьтай гэж байна шүү дээ. Энэ ямар учиртай юм. Хэрлэн тооно нь бас хилийн усны хэлэлцээрээс болоод гацсан уу? Тэгэхээр энэ 2 төсөл чинь явахгүй нь ээ дээ. Энэ та нарын танилцуулсан энэ төсөл дээр чинь бол 1.7, 1.8 их наядыг чинь бол бид нар шийдээд өгчихнө л дөө. 1.14, 1.8 нэг нь 1.8 их наяд нь 2025 оны тодотгол дээр гэж байна. Гэтэл хилийн усны хэлэлцээр шаардлагатай байна. Энэ ямар учиртай юм бэ? Тавхан хувьтай байдаг. Хэрлэн тооно нь тийм асуудлаас болоод гацчихсан. Тэгээд 26 онд хийгдэх мега төсөлд аваачаад тавьчихсан байна.

Тэгэхээр би энэ дээр тодорхой яг хариулт авмаар байна. Яагаад ийм юм болсон бэ? Франц Монголын ураны төсөл Дорноговь аймгийн Улаанбадрах сумд хэрэгжих ёстой. Улсын Их Хурлаар соёрхон баталсан. Энэ ажил явах ёстой. Гэтэл ажлын хэсэг Улсын Их Хурал Засгийн газар дээр байгуулагдсан ажлын хэсэг говийн бүсийн гишүүдийг ерөөсөө оруулаагүй. Говийн бүсийн ард иргэдтэй уулзаагүй соён гэгээрүүлэх ажиллагаа хийгээгүй. Яг гадаа уран эсэргүүцсэн ард түмний жагсаал болж байна. Засгийн газарт тэр хүмүүс тэнэг мангар харагддаг байж болно. Миний хувьд тэр тойргоос сонгогдсон гишүүний хувьд огтхон ч тэнэг мангар биш инээх юм биш шүү. Та инээх хэрэггүй. Инээдтэй санагдахгүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хүмүүстэй хэлэлцээрт оруулах ажлын хэсэг байгуулах үнэхээр тэнд тэр эрэмдэг зэрэмдэг мал төрж байгаа бол нутаг орон уснаасаа хордож байгаа бол яг нүдэн дээр ажлын хэсэг байгуулаад судалгаа хийгээд, шинжилгээ хийгээд олон улсын эксперт томилоод өгөөч ээ гэсэн Учрал сайдад өгсөн албан бичиг 3 сарын.

**С.Ганбаатар:** Нэмэлт нэг минутаар тодруулъя.

**Л.Мөнхбаясгалан:** 3 сарын 19-нд өгсөн өнөөдрийг хүртэл чимээ сураггүй. Туслахаараа хэлүүлсэн нь бид нар ажлаа мэдэж байгаа хийж байгаа чи дуугүй байж бай л гэсэн. Ер нь нэг тийм Улсын Их Хурлын бүсийн гишүүдийг тоодоггүй нэг ийм юм байгаад байгаа юм. Одоо дээрээс нь манай говийн бүсэд 4 боомт байна л даа. Одоо Цагаан дэл болон Өлзий боомтыг шинээр нээх гэж байгаа тийм үү? Гэтэл манай боомтууд ерөөсөө хүн арддаа ашиггүй байдаг. Бид нар өнөөдөр Өмнөговийн иргэд 700, 800 км тойрч Замын-Үүдээр гарч лангуун дээр зарах бараагаа юмаа авчирдаг. Тэр нь нөгөө орон нутагт ард иргэдэд өгөөжөө өгдөггүй. Тийм учраас бүхимдалтай байдаг. Тулга сайдтай энэ асуудлыг тухай бүрд нь ярьж байгаа.

Тэгэхээр надад усны хэлэлцээр дээр яагаад Орхон Онги дээр хилийн ус Хэрлэн тооно хилийн усны хэлэлцээрээс гацсан байх гэж би бодож байна. Одоо хүртэл энэ санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй байна. Энэ дээр хариулт өгөөч. 3 асуулт асууя.

**С.Ганбаатар:** Маш тодорхой асуултууд асуулаа. Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя аа. Бид нар бол эхний шатанд Улаан нуурыг устай болгохоор ажиллаж байгаа. Маш тодорхой санхүүг нь ч гэсэн шийдээд тэрийг бол хийчихнэ гэдэгт эргэлзэхгүй байгаа. Энэ устай холбоотой юмыг Байгаль орчны яам нөгөө хэлэлцээртэй холбоотой юмыг тайлбарлах байх. Улаан нуураа усжуулахад бол ямар ч тийм хилийн хэлэлцээр шаардлагагүй. Тэгэхээр тэрийгээ эхний ээлжид хийчихье ээ гээд маш богино хугацаанд алхъя гэсэн нэг ийм ойлголттой байгаа. Тэгээд тантай санал нэг байгаа. Ер нь цаашдаа энэ эдийн засаг жоохон аятайхан болно амьдарна гэж байгаа юм бол устай байх хэрэгтэй гэдэг гарцаагүй шаардлага байна. Тэрийг хийхгүйгээр цаашаагаа энэ уул уурхайтай холбоотой ч юм уу эсвэл аж үйлдвэртэй холбоотой бодлогууд ер нь ажил хэрэг болохооргүй байна.

Тийм учраас бол бид нар ундны ус ахуйн хэрэгцээний ус гэдэг энэ зүйлийн араас бол маш хүчтэй ажиллана аа. Тэр уран олборлолттой холбоотой технологийн аюулгүй байдлын ойлголтыг бий болгох гэдэг тухайд бол тантай санал нэг байна. Ер нь энэ дээр бол маш нягт ажиллагаа хэрэгтэй юм байна лээ. Их тодорхой байна. Аюулгүй байна гэдгээ нотлоод хэдүүлээ цаашаа явах ёстой. Энэ нотолгоонууд гарах хүртэлх хугацаанд ямар ажлууд хийх вэ гэдгийг бас 7 номер хариулаад явах нь зөв байх. 3 дахь асуулт нь юу байлаа?

Яг зөв боомтыг хариулмаар байна. Ер нь бол боомтыг цаад талаас нь ачаа тээвэр авдаг байх зохицуулалтыг хийгээч ээ гэдэг шаардлагыг би сайдад хэлчихсэн байгаа.

**С.Ганбаатар:** Буяагийн Тулга сайд хариулна.

**Б.Тулга:** Говийн бүсэд бол 4 боомт байгаа гэж та хэллээ. Тэгээд 4 боомт дээр одоогийн байдлаар бол уул уурхайн бүтээгдэхүүн экспортлохоос гадна ялангуяа Гашуун сухайт боомт дээр уг уурхайн бүтээгдэхүүн экспортлохоос гадна нь манай талаас гэрийн даалгавар юу байх ёстой вэ гэвэл хүнсний лабораториуд барьж байгуулах ёстой. Бид шинээр тохижуулж байгаа шинээр бүтээн байгуулж байгаа боомтууд дээр бол барилгын лаборатори хүнсний лаборатори бүгдийг нь тусгаж өгч хөрөнгө оруулалт суулгаж байгаа. Гашуун сухайт боомтын хувьд бол сая Шинэ боомтын цогцолбор өнгөрсөн оны 9 сараас ашиглалтад ороод үйл ажиллагаа явуулаад эхэлсэн.

Энэ дотор лабораторийн барилга нь орчихсон. Одоо харин дотор тохижилтын асуудлыг 2024 оны төсөвт суулгаад тендерээ зарлаад энэ дотор тохижуулалтыг энэ ондоо хийгээд дуусна. Ингэх юм бол Гашуун сухайт боомтоор Эрээний боомттой адилхан Замын-Үүд Эрээний боомттой адилхан хүнсний бүтээгдэхүүн орж гарах бололцоо бүрдэнэ ээ. Шинээр яригдаж байгаа Цагаан дэл уулын боомт Ханги Мандалын боомт дээр ч гэсэн ялгаагүй яг энэ байдлаараа орон нутгийн асуудлыг шийдээд явна гэдэг ийм төлөвлөгөөтэй хөрөнгө оруулалттай ажиллаж байгаа гэж хэлье ээ.

**С.Ганбаатар:** Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

**Л.Мөнхбаясгалан:** Улаанбаатар хот Засгийн газрын төлөөлөл Учрал сайдыг хариуцсан сайдыг говийн бүсийн гишүүдтэй авчир гэсэн шаардлага тавиад байгаа байхгүй юу. Учрал сайд энд очих уу? Энийг би хэнээс асуух вэ? Учрал сайд энэ хуралд орж ирж болох уу?

**С.Ганбаатар:** Асуулт энд хэн хариулах вэ? 7 номерын микрофонд хариулт өгье.

**Д.Далайжаргал:** Мон-Атом компанийн захирал Далайжаргал байна. 3 сарын 21-нд ЗГХЭГ-ын тушаалаар Дорноговь аймгийн Улаанбадрах суманд малчдаас гарсан гомдлын дагуу ажлын хэсэг 4 хоног ажиллаад хэвлэлийн хурал хийгээд бүх тайлан илтгэлүүдээ тавьчихсан байгаа, 1 дүгээрт.

Хоёрдугаарт бид нар хөрөнгө оруулалтын гэрээгээр олон улсын атомын эрчим хүчний гээд л магитегийн хяналтын доор явбал 2 жил тутам магитегаас хяналт тавина гэж гэрээндээ оруулаад тусгачихсан байгаа. ШУА улирал болгон хяналт хийгээд явж байгаа.

**С.Ганбаатар:** 7 номерын микрофонд гүйцэж хариулъя.

**Д.Далайжаргал:** Үгүй ээ тэрийг Учрал сайд мэдэх байх аа. Би Учрал сайдын өмнөөс хариулж мэдэхгүй байгаад байгаа юм. Очно очно гэж хариуллаа.

Далайн Батбаяр гишүүн асуулт асууя.

**Д.Батбаяр:** Энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Тэгээд Засгийн газраас хэрэгжүүлж байгаа 14 мега төслийн талаар танилцуулга хийж байна. Тэгээд энэ 14 мега төслөөс яг Дархан-Уул аймагт хэрэгжиж байгаа гангийн үйлдвэрлэлийн төслийг нь илүү хэрэгжих боломжтой юм болов уу гэж бодитой юм болов уу гэж хараад байгаа байхгүй юу. 10 хэдэн төслөөс нь алаг үзээд байгаа юм бол биш л дээ.

Яагаад гэхээр илүү боломжтой байна гэж харж байгаа манай Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын нутагт эрчим хүч хувийн хэвшлийн эрчим хүчний төсөл хэрэгжиж байна.

Тэгэхээр эрчим хүчний дутагдал нь гайгүй. Ахиад энд Түшихийн Шарын голын нүүрсний ордууд нь байна. Мөн төмрийн ордууд нь байгаад байгаа. Нэг дор цугларчихсан байгаад байгаа учраас яг энэ гангийн үйлдвэр маань ер нь явчих боломжтой байгаад байгаа юм. Түүхий эдүүд чинь хамгийн чухал байхгүй юу. Тэгээд манай Дархан Сэлэнгэ аймгийн иргэдийн хүлээлт бол маш их байгаад байна. Хангалттай их ажиллах туршлагатай ажиллах хүчин байгаад байдаг. Тэгээд ер нь үйлдвэр тийм технологийн парк нь ашиглалтад орчих юм бол ажиллах бүрэн боломжтой байгаад байгаа юм.

Гэхдээ иргэдээс нэг гомдол ирээд байгаа юм аа. Уг нь сайхан төсөл боловчиг яг энэ төслийг хэрэгжүүлж байгаа энэ төслийн баг яг ямархуу шугамаар сонгон шалгаруулж томилогдсон бэ гэдэг дээр асуудал гараад байгаа юм шиг байгаа юм.

Иргэд бол ээдээ гээд ер нь эргэлзэх байдалтай болчихсон байна. Тэгэхээр энэ дээр энэ хариуцаж байгаа Эдийн засгийн яам, Аж үйлдвэрийн яам анхаарч ажиллаад яг энэ сонгон шалгаруулалтаа ямархуу журмаар ер нь хийсэн юм бол яаж төслийн удирдлагыг ер нь ямархуу байдлаар сонгож байгаа юм болоо гэдэг дээр нэг хариулт авчихмаар байна 1 дүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт. Их анхааруулахаар зүйл гэвэл энэ Аж үйлдвэржилтийн байнгын хороо хуралдаж байгаа учраас Эдийн засгийн яам байгаад байгаа учраас, Аж үйлдвэрийн яам байгаад байгаа учраас би нэг энэ Хөтөлийн цемент шохойн үйлдвэртэй холбоотой нэг тийм анхааруулга өгчихье гэж бодоод байна.

Тэгэхээр энэ манай Хөтөлийн цемент шохойн үйлдвэр маань яг одоо Хятадын цементээс 2 дахин илүү үнэтэй цемент үйлдвэрлэж байгаа. Өртөг нь ийм өндөр үнэтэй байгаад байгаа. Яагаад вэ гэхээр энэ цемент шохойн үйлдвэр маань өөрөө тээврийн үйлчилгээ хийж байгаа юм. Өөрсдийн гэсэн вагоноо ажиллуулна ахиад дээр нь зүтгүүрээ маллана. Тэгээд дээр нь ахиад уурын зуух ажиллуулдаг. Хөтөл хотын уурын зуухыг ажиллуулдаг. Тэгээд зуурмагийн узель байхгүй. Өнөө шүүхийн маргаантай байгаад байгаа учраас ажиллах боломж байхгүй. Тэр Хөтөл хотод Сайхан суманд босож байгаа аливаа нэгэн бүтээн байгуулалт нь бүгдээрээ хотоос зуурмагаа татах хэрэгтэй болчхож байгаа байхгүй юу. Энэ чинь эмгэнэл. Яг хажууд талд нь цементийн үйлдвэр байгаа мөртөө зуурмагаа хотоос татдаг.

Ийм учраас бүтээн байгуулалтын өртөг өндөр болчихоод байгаа юм. Ийм учраас заавал гаднаас цемент авч нөгөө доллар маань гадагшаа гарах урсгал нь нэмэгдээд байгаа юм. Худалдааны тэнцэл.

**С.Ганбаатар:** Далайн Батбаяр гишүүнд гүйцэж асуулт асуух боломж өгье. Нэг минут.

**Д.Батбаяр:** Тэгээд технологийн ганц түүхий эд болох нүүрсээ авъя гэхээр Тавантолгойн нүүрсийг авъя гэхээр заавал биржээр худалдаж авах хэрэгтэй болчихоод байдаг, дотоодын худалдаа хийх болоод. Ингэхээр өртөг багатай цемент үйлдвэрлэх боломж байхгүй. Монголын барилгын салбар үндэснийхээ үйлдвэрлэлийн цементийг хэрэглэх боломж байхгүй болчихоод байгаа юм. Улс



бизнес хийхийн гол үр дүн нь ерөөсөө энэ байхгүй юу. Ийм учраас үйлдвэрлэл хөгжихгүй байгаад байгаа юм. Ийм учраас доллар үнэтэй байгаад байгаа юм. Гадагшаа гарч байгаа доллар их байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хөтлийн цемент шохойн үйлдвэртэй холбоотой энэ нөхцөл байдал дээр та бүхнийг нэг анхаарчхаасай гэж хүсмээр байна. Энэ боломжийг гаргаад хэлчихье. Тэгээд асуултынхаа хариултыг авчихъя.

**С.Ганбаатар:** Нэг номерын микрофон. Дараад нь 5 номерын микрофонд хариулт өгнө өө.

**Г.Ганхуяг:** Эрдэнэс УТП компанийн төсөл хэрэгжүүлэлтийн газрын менежер Ганхуяг Батбаяр гишүүний асуултад хариулъя.

Гангийн цогцолбортой холбоотой ер нь бол Дархан Төмөрлөгийн үйлдвэр Үндэсний төмөртэй овоо орд нь өөрөө Эрдэнэс Монгол нэгдлийн харьяа компани байгаа. Тэр утгаараа бол энэ төслийг Эрдэнэс Монгол нэгдэл энэ гангийн цогцолборын төслийг хариуцаж явж байгаа.

Энэ нь Дархан үйлдвэр технологийн паркийн хүрээнд хэрэгжих төсөл учраас манай Эрдэнэс УТП компани үндсэндээ гангийн цогцолборын төслийг бүрэн хариуцаж ажиллаж байгаа. Одоо манай компанийн удирдлагууд нь мэдээжийн хэрэг сонгон шалгаруулалтаар томилогдсон ийм удирдлагууд ажиллаад явж байна. Яг бусдаар ямар нэгэн байдлаар хөндлөнгийн яг гүйцэтгэл юу гэдэг юм барилга угсралтын ажил ч юм уу гүйцэтгэл хийх компани одоохондоо тодруулж сонгосон юм байхгүй байгаа. Тэгээд иргэд яг ямар гомдолтой байгаа, ямар асуудалтай байгаа талаар надад ямар нэгэн мэдээлэл одоохондоо алга байна.

**С.Ганбаатар:** Мэдээлэлгүй байна гэж юу ярьж байна энэ чинь одоо энэ Дэгийн тухай хуулийн 9.16-д заасан байгаа шүү дээ. Тайлбар хийж асуултад хариулж байгаа албан тушаалтан үнэн зөв мэдээллийг өгөх, асуултад товч тодорхой хариулах үүрэгтэй. Мэдээлэл байхгүй байна л гэж байна. Тэгээд гишүүн хариултыг хангалтгүй эргэлзээтэй гэж үзвэл тухайн асуултын хариуг 2 хоногийн дотор бичгээр өгөхийг шаардаж байх эрхтэй. 2 хоногт өгдөг хүн ч гэж ховор доо. Тэгээд л өнөөдрийгөө аргалбал тэгээд л худлаа хулхидаад л алга болдог шүү. Энэ бол гишүүдийн эрхэнд гэхээсээ илүү сонгогчдын ард түмний эрхэнд та нар халдаж байгаа хэрэг шүү. Ингээд нэг минутаа авчихсан хэдий ч гэсэндээ Далайн Батбаяр гишүүнд сая маш хангалтгүй хариулт өгсөн учраас дахиж тодруулж асууя. Тэгээд Эдийн засгийн асуудал хариуцсан асуулт байгаа шүү 2 номерт хариулах юм уу?

Ингээд Далайн Батбаяр гишүүн нэг минут.

**Д.Батбаяр:** Та хэд их ажилтай байгаа байлгүй. Бүгдээрээ л өглөө 9-өөс орой 6 цаг хүртэл хийж байгаа. Бид нар ч гэсэн энэ чинь хангалттай ажилтай байгаа шүү дээ. Тэгээд бид нар асуусан болоод та нар хариулсан болоод ингээд дуусаад л нэг ёжилж инээгээд дуусдаг. Мэдээлэл байхгүй байна гээд. Ингээд дуусах юм бол өнөөдрийн энэ хурлыг хийх та нар энд оролцох ямар ч шаардлага байхгүй шүү дээ. Тэгээд мэдээлэл авахгүй иргэдийг төлөөлж байгаа учраас иргэдийн санал бодлыг би хэлж байгаа байхгүй юу. Миний миний авсан мэдээллийг та аваагүй байна гэдэг байдлаар хэлээд байгаа юм шиг байна тийм үү?



Тэгэхээр энэ сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг надад 2 хоногийн дотор бичгээр гардуулж өгөх хэрэгтэй байна.

Хоёрдугаарт нь тэр төрийн өмчийн үйлдвэрийн газрууд нэг саалийн үнээ шиг ажиллаад байгаа байдал дээр ямархуу бодлого ер нь барьдаг юм. Энэ Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн талаар ер нь мэдэж байгаа зүйл байгаа юу үгүй юу? Тэн дээр хариулт авчихмаар байна.

**С.Ганбаатар:** Хариултыг 2 номерт Эдийн засгийн яамны зүгээс хариулна. Мөн Аж үйлдвэр\* эрдэс баялгийн яамны зүгээс хариулт өгөх ёстой шүү саяынх дээр.

**Ц.Эрдэнэбат:** Эдийн засаг, хөгжлийн яам, Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар Эрдэнэбат. Батбаяр гишүүний асуултад хариулъя. Хөтөлийн цемент шохойн үйлдвэртэй холбоотой асуудлууд нэлээд ээдрээтэй мухардалд орчихсон нөхцөл байдалтай байгаа. Энэ юунаас улбаатай вэ гэхээр Хөгжлийн банкнаас зээл өгчихсөн байдаг. Тэгээд Хөгжлийн банкны өгсөн зээл шүүхийн түвшиндээ юу болсон гэхээр тэр зээл авсан иргэн нь нас бараад өв шилжүүлэх асуудал үлдсэн. Энэ процесс дунд ТӨБЗГ-аас Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийг авч ажиллуулсан. Тэгээд энэ асуудал ойрын үед яригдаж байгаа. Хөгжлийн банк өөрөө авахын тулд цемент Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн энэ өмчлөлийн асуудлуудыг сая ТУЗ-ийн хурлаараа шийдсэн. Удахгүй Засгийн газрын хуралд оруулаад өмчлөлийн асуудлыг нэг талдаа гаргана.

Тэгээд 1 талдаа гаргах процесс. Дараа нь яг Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийг яаж ажиллуулах вэ, яах вэ гэдэг төлөвлөгөө нь гарах юм. Тэгэхгүй болохоор одоо яг тэр өмчлөлийн болон энэ үйл ажиллагаатай холбоотой маргаанууд нь яг эцэслэгдээгүй байгаа учир бас нэг тодорхой асуудал үүсчихсэн байгаад байгаа юм. Нөхцөл байдлын хувьд.

Тэгэхээр тун удахгүй бид яг энэ Хөгжлийн банкны гарсан шийдвэр Засгийн газрын шийдвэр гармагц мэдээллийг өгье. Ер нь яг өнгөрсөн хугацаанд болсон бүх мэдээллүүд нь байна. Би энэ мэдээллийг бичгээр өгүүлж болж байна аа. Яг хэдэн оноос яг ямар процесс болсон юм. Хэдэн төгрөг хэн зээлсэн юм. Тэр мөнгө нь яаж зарцуулагдсан юм. Тэгээд хаана очиж шүүхийн ямар шийдвэрүүд гараад асуудал үүссэн бэ гэдэг талаар мэдээллийг хүргүүлье ээ.

**С.Ганбаатар:** Ингээд Дуламын Бум-Очир гишүүнийг асуултад оруулаарай. Ингээд Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууна аа.

**Д.Үүрийнтуяа:** Баярлалаа. Надад тодорхой хэд хэдэн асуулт байна. 1 дүгээрт зэсийн баяжмал хайлах боловсруулах үйлдвэрийн санхүүжилт 1.1 тэрбум доллар гэж танилцуулж байна. ТЭЗҮ тодотгол хийгдээгүй санагдах юм? Одоо байгаа ТЭЗҮ-ээр бол нэг 800 орчим сая ам.долларын санхүүжилт байх ёстой. Энэ яагаад өөрчлөгдсөн юм бэ?

Хоёрдугаарт энэ санхүүжилтийг ямар зарчмаар шийдэх гээд явж байгаа юм бид нар зарчимд тохирч байна гээд байна. Ямар зарчмаар шийдэх гэж байгаа юм?

Ер нь энэ төсөл дээр Уул уурхайн яам, Эрдэнэс Монгол, Эрдэнэт үйлдвэр ямар чиг үүрэгтэй оролцоод байгаа юм бэ? Хэн юу хариуцах гээд байгаа юм бэ? Бүх юм нь бэлэн болчихсон төсөл өнөөдрийг хүртэл санхүүжилтийнхээ асуудлыг хэн юу

хариуцахаасаа хамаараад ажлаа эхлүүлж чадахгүй байна гэж би харж байгаа юм. Энэ дээр тодорхой хариулт өгөөч, нэг.

Хоёрдугаарт 14 мега төслийн ерөнхий мэдээллүүд өгөгдөж байна. Эдгээр төслүүдийг хөрөнгө оруулалтын үр өгөөжийнх нь хувьд эрэмбэлж хийсэн санхүү эдийн засгийн тооцоолол байна уу?

Гуравдугаарт миний хувьд энэ валью эксченжийг энэ хөрөнгийн солилцооны асуудлыг бол олон улсад хэрэгждэг зарчмынх нь дагуу би дэмжээд байгаа юм. Гэхдээ өнөөдөр та бүхний ярьж байгаагаар сайдын ингээд хариултад хэлж байгаагаар орон сууцын төсөл санхүүжүүлэгч юм шиг л юм ярьчих юм. Би зөв ойлгов уу эс үгүй буруу ойлгочхов уу? Валью эксченж дээр Эдийн засгийн хөгжлийн яам ямар бодлого барьж байгаа юм бэ? Хэрхэн яаж санхүүжилтийн тогтолцоог үүсгэнэ гэж бодож байгаа вэ? Төлөвлөж байгаа вэ? Би өнөөдөр Байнгын хорооны дарга Ганбаатар даргадаа талархлаа илэрхийлмээр байгаа юм.

Би 3 сарын 18-ны өдөр Эдийн засгийн хөгжлийн сайдад хандаж Тэргүүн шадар сайдад хандаж танай яам руу албан бичиг явуулсан. 14 мега төслийн зураг төсөл ТЭЗҮ, эдийн засгийн холбогдох тооцоо судалгааг явуулаач ээ гэж хүсэлтээ гаргасан. Бичгийн хариу ирээгүй. Сарын хугацаанд та нар хариу өгөх ёстой. 4 сарын 17-ны өдөр би өөрийнхөө нэртэй Улсын Их Хурлын гишүүн болгон шуудангийн хаягтай шүү дээ. Шуудангийн хаяг дотроосоо ямар ч гарын үсэггүй, ямар ч албан бичиггүй хэдэн хуудас цаас олсон. Яам руу ярьсан. Ажлын албаны зүгээс сайдын туслах руу. Хэн хэзээ явуулсан нь мэдэгдэхгүй алга болсон. Би бичгийнхээ хариуг нэхсэн. Надад хариу өгөөгүй.

Тийм учраас би байнгын хорооны даргад хүсэлт тавьсан юм. Байнгын хороон дээр энэ мэдээллийг сонсмоор байна гэж. Энэ ажлуудыг эрчимжүүлэх ажлын хэсэг байгуулж ажиллах шаардлагатай байна гэж. Би минутаа нэмээд авчихъя дарга.

**С.Ганбаатар:** Нэг минутыг сунгаж өгье.

**Д.Үүрийнтуяа:** Тэгээд өнөөдөр Байнгын хорооны дарга маань 4 сарын 10-ны өдөр санал хүсэлт явуулаад 21-ний өдөр энэ албан бичгийн хариу Байнгын хороон дээр иржээ. Надад 4 сарын 17-ны өдөр гэсэн хаягласан албан бичгийг би 4 сарын 23-ны өдөр Улсын Их. Хурлын Тамгын газрын бичиг хэргээр хүлээж авсан бүртгэлтэй хариуг хүлээж авсан.

Байнгын хороонд хариу явуулах болохоороо ирдэг юм байна. Цаашдаа хэдүүлээ ямар зарчмаар ажиллах юм бэ? Улсын Их. Хурлын гишүүний тавьсан санал мэдээлэл хүссэн энэ албан бичгийн хариуг Эдийн засгийн хөгжлийн яам ямар ч байсан хэрэгжүүлэхгүй юм байна. Байнгын хороогоороо дамжиж харьцаж байх ёстой юм уу яах ёстой юм. Энэ дээр тодорхой хариу өгөөч?

Улсын Их Хурлын гишүүн гишүүн Эдийн засгийн хөгжлийн яамнаас материал авах эрхтэй юу эрхгүй юу?

**С.Ганбаатар:** Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн яамны зүгээс 2 номерын микрофон дээр. Протокол бичиж байгаа учраас нэр ус албан тушаалаа хэлнэ. 2 номерын микрофоныг нээж өгье.

**Ц.Эрдэнэбат:** Эдийн засаг хөгжлийн яам Эрдэнэбат. 1 дүгээр асуулт нь Зэсийн үйлдвэрийн үнэ өртөг өөрчлөгдсөн үү гээд. Бид нар одоо яг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө 2026-г засгаар батлуулаад Улсын Их Хурал өргөн барьж байгаа. Энэ дээр бид нарт байгаа тоо нь бол бид нарт одоо төлөвлөгдөөд явж байгаа нь бол нийт 2.5 их наяд, 2026 онд 500 орчим тэрбум төгрөг төсөвлөгдөөд явж байгаа юм байна. Яг ажил чиг үүргийн хүрээнд бол Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам хариулах байх.

Гишүүний асуусан албан бичигт манайхаас хариу өгсөн юм байна. Өгөхдөө жоохон техникийн алдаа гарсан юм байна. Тэрэнд хүлцэл өчье. Хэрэв тэрэн дээр нэмж танд асуухаар тайлбар байгаа бол бид 2 хоногийн дотор материалаа сайжруулаад өгье.

Тийм. Валью эксченжийн хувьд бол одоогоор ер нь хэд хэдэн саналууд яригдаж байгаа. Энэ валью эксченж яг энэ одоогийн бид нарын энэ ялангуяа баялгийн санг арвижуулах цогц төлөвлөгөөний хүрээнд орж ирнэ гэж бодож байгаа. Яг одоогоор валью эксченж дээр хийгдсэн ажил бол яг бид нарын авсан мэдээллийн хүрээнд байхгүй байна. Валью эксченж ер нь байх ёстой гэдэг байр суурь байгаа. Тэрийгээ бид юу гэж томъёолж явж байгаа вэ гэхээр баялгийн санг арвижуулах хүрээнд энэ эрдэс баялгийн салбар энэ чиглэлээр нэгдсэн цогц арга хэмжээ хийнэ гэж улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдаад явж байгаа.

**С.Ганбаатар:** 5 номерт хариулна. Төслийн үр өгөөжийн талаар тодорхой хэлж өгнө шүү. Дараа нь Буяагийн Тулга гишүүн хариу хариулт өгнө. 5 номерын микрофоныг нээж өгье.

**С.Сүхбат:** Сүхбат Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Аж үйлдвэрийн бодлогын газрын дарга. Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийн хувьд бол 2022 онд батлуулсан ТЭЗҮ-ээр 762 сая доллар хэвээрээ байгаа. Удахгүй ТЭЗҮ-ийн тодотгол орж ирнэ. Энэ маань нөгөө хүхрийн хүчлийг саармагжуулах хүхрийн хийгээр саармагжуулж элементийн хүхэр болгох туршилтынхаа ажилтай холбоотойгоор болон бусад асуудлаараа ингээд тодотгоод удахгүй яаман дээр хэлэлцэнэ ээ. Нийт тэр 1.1 тэрбум доллар гэдэг нь нийт нөгөө үйлдвэр технологийн паркийнхаа хүрээнд дагаж баригдах үйлдвэрүүдтэйгээ ингээд хамтатгаж оруулсан байна аа.

Одоо бол Монгол Улсын Засгийн газраас Эрдэнэт үйлдвэрийг түшиглэсэн.

**С.Ганбаатар:** Буяагийн Тулга сайд хариулъя.

**Б.Тулга:** Үүрийнтуяа гишүүний асуулт дээр энэ баялгийн солилцоон дээр товчхон хариулт өгчихье. Энэ баялгийн солилцоон дээр хуулийн төсөл Улсын Их Хурал руу Засгийн газраас өргөн барьж байгаа гол концепц нь бол түрүүн яригдсан Зүүн босоо тэнхлэгийн төмөр зам магадгүй Улаанбаатар хотын тойрог зам гэсэн энэ том нийгмийн ач холбогдолтой энэ төслүүд дээр төлбөрийн баталгаа гэдэг юм уу, төлбөрийн хэлбэрээрээ олон улсад хэрэглэгддэг энэ баялгийн солилцооны зарчмыг оруулж ирье гэж байгаа. Засгийн газраас төслүүдээ эрэмбэлээд Улсын Их Хурал дээр орж ирж шийдэхээр байгаа.

Тэгэхээр энэ ямар нэгэн байдлаар нөгөө өмнө аль нэг компанийн захирлын ширээн дээр зурагддаг байсан ийм үйл явдал болохгүй. Аливаа баялгийн

солилцоогоор явах төслүүд бол Засгийн газраар эрэмбэлэгдээд Их Хурал дээрээ батлагддаг энэ зарчмаар явъя гэсэн хуулийн концепц орж ирж байгаа. Энэ бол ганцхан юу гэдэг юм Эрдэнэс Тавантолгой дээр бас ярих асуудал биш. Түрүүн Гантөмөр сайд хэлсэн бүх төрлийн ордууд дээр тухайн бүс нутагтаа үр ашигтай ийм төслүүдийг санхүүжүүлэх ийм төлбөр.

**С.Ганбаатар:** Ойлголоо. Ажлын хэсгийнхэнд болон нийт гишүүдийн анхааралд хэлэхэд ер нь гишүүний асуултад хугацаандаа хариулт өгөхгүй бүрэн дүүрэн үнэн зөв хариулт өгөхгүй бол гишүүдийн ард түмэндээ мэдээлэл өгөх үүрэг буюу ажлаа хийхэд нь садаа болж Үндсэн хуулийн цэцэд шууд очдог юм шүү. Би чинь хэд хэдэн удаа хэдэн сайдыг Үндсэн хуулийн цэцэд өгч байсан. 30 хоног, 14 хоног гээд тэр хуульд заасан хугацаандаа өгөхгүй бол энэ Үндсэн хуулийн цэцийн асуудал болж хувирдаг юм шүү. Гишүүд болон энэ ажлын хэсгийнхэн онцгой анхаарч энэ дээр хариуцлагатай байгаарай. Ард түмний мэдэх эрхэд халдаж болохгүй ээ бид.

Ингээд зарим асуултад маш гоомой хариулсан учраас Үүрийнтуяа гишүүнийг тодруулж нэг минут асууна уу. Хөрөнгө оруулалтынхаа өгөөжийг хариул даа. 2 номерын микрофон дээр.

**Ц.Эрдэнэбат:** Эдийн засаг хөгжлийн яам Эрдэнэбат. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2024-өөс 2028 онд бид нар нэлээд олон төсөл арга хэмжээнүүдийг Улсын Их Хурал дээр баталж өгсөн. Үүн дотор 149 төсөл арга хэмжээг бүр тодорхой бид авч үзээд 149 дотор энэ 14 мега төсөл явж байгаа. 149 төслийн эдийн засгийн, нийгмийн, байгаль орчны болон олон талаас нь үр өгөөж тооцооллуудыг бид хийгээд явж байна. Яг эцэслээд яг эрэмбэ нь бүүр яг төгс төгөлдөр хувилбар руу очиж амжаагүй байна. Яагаад гэхээр нэлээн загварчлалууд хийх, бид нарын нэлээд тооцооллуудыг олон талаас нь харах бас олон улсад бид нарын амласан Эс Ти Жи нөгөө Тогтвортой хөгжлийн зорилтууд болон тэр хүлэмжийн хий энэ тэр гээд энэ талаас нь бодох гээд хугацаа жоохон орж байгаа. Яг одоогийн түвшинд эрэмбэлчихсэн явж байгаа ажлынхаа.

**С.Ганбаатар:** Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

**Д.Үүрийнтуяа:** 1 дүгээрт Хайлах үйлдвэр дээр үйлдвэр технологийн парк дээр 1.1 гээд байна л даа. 800 сая доллар хайлах үйлдвэрийнх юм бол 300 сая доллар юун дээр тавиад байгаа юм бэ тэрийг тодорхой болгож өгөөч.

Хоёрдугаарт Эрдэнэбат Эдийн засгийн хөгжлийн яам гээд та яг ямар ажил хариуцдаг билээ. Энэ Хайлах үйлдвэрийн төсөл дээр хэн юу хариуцах юм бэ? Нэг тодорхой гаргаж өгөөч. Би асуултаа дахиад тавья. Эрдэнэс Монгол юу хариуцах юм, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам юу хариуцах юм? Уул уурхайн яам юу хариуцах юм? Эрдэнэт үйлдвэр юу хариуцах юм? Өнөөдөр хамгийн нөхцөл боломж нь бүрдчихсэн байгаа төсөл өөрөө энэ шүү дээ. Тэгээд юун дээр гацаад байгаа юм? Санхүүжилтийн асуудлыг шийдэхэд гацаад байгаа юм. Бид санхүүжилтийн зарчмыг ярьж байна л гээд байна. Хэн хаана юу яриад, хэн хариуцаад яваа юм бэ? Хэн юу хариуцах ёстой юм бэ? Энийг тодорхой болгож өгөөч ээ?

**С.Ганбаатар:** 5 номерын микрофонд хариулт өгье.

**С.Сүхбат:** Сүхбат Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам. Манай яамны хувьд бол энэ мега төслүүдийг бодлогын хэмжээнд дэмжих ёстой. Хууль эрх зүйн хүрээнд. Эрдэнэс Монгол компанийн охин компани болох Эрдэнэс үйлдвэр технологийн парк одоо яригдаж байгаа төрийн өмчийн 6 үйлдвэр технологийн паркийг хэрэгжүүлж үйлдвэр байгуулах чиг үүрэгтэй ийм компани байгаа. Энэ компанийн хүний нөөцийг бүрдүүлэхэд яамны зүгээс ямар нэгэн чиг үүрэг удирдлагаар хангадаггүй, хүн томилдоггүй. Түрүүн өмнө нь асуулт гарсан учраас давхар хариулаад хэлчихье ээ гэж бодож байна аа.

**С.Ганбаатар:** 300 сая долларын төсөл тэр талаар дэлгэрэнгүй тайлбарлаарай нэг минут. 1 дүгээр номерын микрофонд хариулт өгье.

**Г.Ганхуяг:** Эрдэнэс УТП компани Ганхуяг. Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Үндсэндээ Эрдэнэт зэс боловсруулах цогцолборын нийт хөрөнгө оруулалт нь 1.1 тэрбум. Түрүүн хэлсэн зэс хайлуулах үйлдвэр 762 сая доллар. Үүн дээр нэмэгдээд нурвал дуусах буюу SXW гэсэн үйлдвэр байгаа. Мөн молибдены боловсруулах үйлдвэр, Эрдэнэт машин цогцолбор. Мөн кабель утасны үйлдвэр гэсэн ийм төслүүд байгаа. Эдгээрээс жишээ нь бол исэлдсэн үйлдвэрийн гадаадын төсөл үйлдвэрлэх дуусгах үйлдвэрийн хөрөнгө оруулалт 60 сая, молибдений боловсруулах үйлдвэрийн хөрөнгө оруулалт 40 сая доллар гэх мэт. Ингээд бусад дэд бүтэцтэйгээ нийлээд үндсэндээ 101.1 тэрбум гэсэн ийм тоо гарч байгаа.

**С.Ганбаатар:** Зарим асуулт нь тодорхой бус тохиолдолд 2 өдрийн дотор та нар бас бичгээр гишүүдэд хариулт өгөөрэй.

Тэгээд Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууна.

**Д.Бум-Очир:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Нэг хуулийн заалтыг та бүхэн тэмдэглээд бичээд авчхаарай. Энд ажил хариуцсан олон хүмүүс байгаа учраас. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27.8 гэдэг заалт байгаа. Энийг дандаа хаягчаад болдоггүй учраас би өнөөдөр та бүхэнд анхааруулан хэлье гэж бодож байна. Зам барих, барилга барих, үйлдвэр барих, хот барих, ашигт малтмалыг эрэх, хайх энэ бүх тохиолдолд урьдчилсан судалгаа хийх гэж заасан байдаг юм аа. Ямар судалгаа вэ гэхээр палеонтологи, археологи, угсаатны зүйн судалгаа гэсэн ийм заалт байдаг. Энэ 14 төсөл маань ялангуяа эхэлчихсэн гэж яригдаж байгаа төслүүд маань энэ судалгаануудыг хийсэн эсэхийг мэдмээр дээр байна.

3 судалгаа шүү. Палеонтологи, археологи, угсаатны зүй. Археологи, палеонтологи хоёроо хийлгэчхээд угсаатны зүйг нь миний мэдэхээр ихэвчлэн хаядаг. Би өөрөө угсаатны зүйн мэргэжилтэй хүн учраас мэдээд байгаа юм л даа. Зарим чуулган дээр би асууж байсан хийгээгүй байсан. Би хийгээрэй гэж хүссэн. Энийгээ хийх болов уу гэж найдаж байна. Битгий Монголынхоо соёлын өвд ийм хүйтэн хөндий хандаач ээ гэдгийг би хэлмээр байгаа юм компаниудад. Нөгөө талдаа яг ажил хариуцаж байгаа, шаардлага тавьж байгаа төрийн захиргааны төв байгууллагынхан маань энэ хуулийн заалтыг нэхээч. Биелүүлэхгүй байгаа бол биелүүлээч гэдэг шаардлагыг тавиаач ээ гэдгийг онцгойлон хэлмээр байна аа.

Энэ Юнейскоын конвенцод Монгол Улс элсэн орсо. Энэ конвенцод элсэн орсныхоо хүрээнд Монгол Улсын бас хүлээх ёстой үүрэг хариуцлагын тухай асуудал давхар яригдаж байгаа юм шүү гэдгийг би дурдмаар байна, 1 дүгээр зүйл.



Дараагийн нэг зүйл түрүүн гишүүдтэй би давхцуулахгүй асуухыг бодъё. Газрын тосны үйлдвэр маань нөгөө түүхий эдийн асуудлаа яасан бэ? Бид чинь нэг түүхий эдийн хомсдолтой юм уу, түүхий эд багатай тэгсэн мөртөө үйлдвэр барих гээд байгаа асуудал зөндөө ярьсан. Үгүй ээ тэгээд үйлдвэрээ барьчихлаа гээд бодоход нөгөө түүхий эд нь байхгүй хорин хэдэн хувийн нөөцөө ашиглаж ажиллана. Үлдсэн 80 хувь нь ингээд нөөцөө ашиглаж чадахгүй юм шиг ийм зүйлс яригдсан. Хятадын талтай бид нар зөвшилцөж тэр нөөцийг 80, 100 хувьд хүртэл ажиллах тэр боломжийг нь эрэлхийлнэ гэдэг ийм зүйл хамгийн сүүлд миний мэдэхээр чуулган дээр яригдаад өнгөрсөн.

Энэ тал дээр урд айлтайгаа ярилцаж хэлэлцэж ахиц дэвшил гаргуулж чадав уу? 2028 оны 12 сарын 30-нд билүү 31 онд нөгөө газрын тосны үйлдвэр маань ашиглалтад орох гээд байгаа. Тэр үед бид түүхий эдтэй байх уу, үгүй юу гэдэг асуудлыг та хэд маань ямар түвшинд хөөцөлдөж байна вэ гэдэг энэ 2 асуултад хариулт авъя аа.

Баярлалаа.

**С.Ганбаатар:** Хариулт Газрын тосны үйлдвэрийн газрын талаар хариулт өгнө. 2 номерын микрофонд хариулт өгнө. Дараа нь 6 номер.

**Ц.Эрдэнэбат:** Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг хөгжлийн яам Эрдэнэбат. Чухал асуудал учраас нөгөө археологи палеонтологи гэсэн би өөрөө яг саналаараа археологи, палеонтологийн мэргэжлийн зөвлөлд сая орсон байгаа.

Тийм учраас энэ чиглэлээр онцгой анхаараад энэ яригдаж байгаа төслүүд дээр яг төсөл бүрээр нь танд мэдээллийг ойрын үед гаргаж өгье өө. Тэрнээс яг одоо нөгөө төсөл болгоныг хариуцсан хүмүүс байхгүй учраас яг нарийвчилсан мэдээлэл надад байхгүй байна. Танд бичгээр гаргаад өгчихье өө. Газрын тостой холбоотой асуудлыг 6 номерын микрофонд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас хариулна.

**С.Ганбаатар:** 6 номерын микрофонд хариулт өгнө. Дараа нь 7 номерт өгнө өө.

**Н.Хишигдалай:** Аж үйлдвэр эрдэс баялгийн яамны Газрын тосны БХЗГ-ын дарга Хишигдалай. Манай улсын хувьд бол ашиглалтын баталгаат нөөц 43.6 сая тонноор батлагдсан байдаг. Үүний 11 сая тонныг одоогоор олборлож экспортлоод байна. Үлдсэн нөөц бол 33 орчим сая тонн нөөц байна. Газрын тосны батлагдсан нөөц үйлдвэрийг бол 20 жил хангах тогтвортой үйл ажиллагааг явуулах боломжтой. Гагцхүү энэ олборлолтыг хэрхэн нэмэгдүүлэх вэ нэмэлт хөрөнгө оруулалтуудыг хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг асуудлаар олборлолт ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа. БНХАУ-ын төрийн өмчит 2 компанитай бол бид нар хэлэлцээрийн ширээний ард суугаад тогтмол асуудлыг ярилцаж байгаа. Хамгийн сүүлийн мэдээллээр өнгөрсөн 4 дүгээр сард БНХАУ-ын Петро Си Эн Пи Си компани буюу Хятадын Газрын тос корпорацын судалгаа шинжилгээний хүрээлэнгийнхэн хүрч ирсэн.

**С.Ганбаатар:** 7 номерын микрофонд.



**Д.Далайжаргал:** Далайжаргал байна. Ямар ч уул уурхайн компани байгаль орчны нарийвчилсан үнэлгээ ерөнхий үнэлгээ гэж 2 юмыг заавал хийлгэдэг юм аа. Хайгуулын лиценз авахдаа байгаль орчны ерөнхий үнэлгээ, ашиглалтын лиценз авахдаа байгаль орчны ерөнхий үнэлгээ гэж хийлгэдэг. Энэ дотор тэр таны яриад байгаа хуулиараа заалттай 14-өөс 15 зүйл ордын нэг нь таны яриад байгаа соёлын, археологийн үнэлгээ хийдэг. Бадрах Энержи компани энийг нь бүгдийг нь хийлгэчихсэн. Зөвхөн энэ үнэлгээ хийлгэхээс гадна 5 жил тутам англи хэлээр апдэйт хийлгэдэг юм. Энийгээ заавал хийлгээд явдаг. Та буруу ойлгосон байн. Энийгээ хийлгээд явсан шүү.

**С.Ганбаатар:** Дуламын Бум-Очир гишүүн тодруулж асууя.

**Д.Бум-Очир:** Хийлгээгүй ээ гэдэг мэдээллийг та өөрөө надад бүлгийн хурал дээр өгсөн учраас би хийлгээгүй юм байна гэдэг ойлголттой явж байгаа.

Би уучлаарай таныг гүтгэж байгаа болж хувирч байх шиг байна. Тэр юу энэ тэрийг нь үзье хийлгээгүй гэдэг мэдээлэл авсан учраас би чуулган дээр яг энэ асуудлыг ярьсан. Та хэрвээ хийлгэчихсэн гэж байгаа бол надад хийлгэчихсэн тэр судалгааныхаа тайланг хүргүүлчихгүй юу. Хэн хэнийгээ хэрвээ би таныг магадгүй гүтгэсэн бол буруу мэдээлэл авсан бол түрүүлээд уучлалт хүсчихье. Буруу ойлголцсон байхыг үгүйсгэхгүй. Хийлгэчихсэн байгаа бол би их баяртай байна.

Гэхдээ би тэр хийлгэчихсэн тайланг нь нэг танилцаад үзчихвэл илүү зөв байх болов уу гэж бодож байна. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Одоо ингээд асуултуудад хариулт авлаа. Тэр нягталж бичгээр явуулах юм байна манай Бум-Очир гишүүнд явуулаарай.

Би нэг гуравхан зүйл тодруулчихмаар байх юм.

Нэгдүгээрт зарим ОХУ болон Германы, Польшийн элчин сайдуудтай би уулзаж байсан. Элчин сайдууд энэ мега төслүүдийнхээ олон улсын тендер зарлаж байгаа энэ мега төслүүдийнхээ материалыг өгөөч ээ гэж Аж үйлдвэрийн бодлогын байнгын хороон даргаас хандаж асуудаг. Тэгээд би бол өөрөө тийм материалыг өгөөд явуулах эрх надад байхгүй. Гадаад явдлын яам руугаа бичиг явуулсан. Та нар энэ холбогдох зүйлүүдээ энэ Элчин сайдуудад явуулж байгаа юу? Надаас ингээд асуудаг 1 дүгээр асуулт.

Хоёрдугаарт Газрын тосны үйлдвэрийн газар дампуурчихсан. Би өөрөө хэрвээ энийг буруу ярьж байгаа бол би өөрөө хариуцлага үүрнэ шүү дээ. Хүн гүтгэсэн гээд нөөц байхгүй, ус байхгүй, ТЭЗҮ нууцад орчихсон. Надад ирсэн. ТЭЗҮ баталсан гарын үсэг ч байхгүй шүү. Тэгээд би ҮАБЗ рүү бичгийг нь явуулж байна одоо. 7 хуудас цаас явуулж байна. Би бүүр хамгийн товчхоноороо. Нууцад байгаа учраас би дэлгэрүүлж чадахгүй байна. Миний асуулт хэн нь хариулах юм бол энэ хүнд үйлдвэр нь хариулах юм уу? Газрын тосны үйлдвэрийн газар гэдэг энэ 2.2 тэрбум долларын төсөл өдөр өнгөрөх тусам 100, 100 сая долларын өрөнд шчошиг гүйж байгаа энэ төсөл дампуурчихсан гэдэг нь ингээд бүр ингээд улс даяар яриад байхад би газрын тосны үйлдвэрийг ерөөсөө эсэргүүцээгүй шүү дээ. Газрын ойр дайны бага дээр наадхаа өөрчлөөд газрын тосны бодит төсөл хөтөлбөр лүү орох тийм боломж байна уу? Наадах чинь бол нохойн замаар орчихлоо гэж монгол хэлээр яриад байна.

Миний асуулт ингэж хэлээд хэлээд байхад одоо 2, 3 жилийн дараа Оюу Толгой шиг бид далаараа тавиулчихсан байна гэдэг дүгнэлт гарахад хэн хариуцлага үүрэх вэ? Энэ дээр хар толгойгоороо хэн хариуцах вэ? Энийг надад хариулж өгөөч ээ. Миний 2 дахь асуулт.

Гурав дахь асуулт бол ураны энэ төсөл тэгээд бүр маш аюулгүй зүгээр бүр цоо зүв зүгээр ээ л гээд л ёоз ёозоор нь бүх PR-аар ярьж байна. Тэгээд Оюу Толгой дээр нэг хэдэн PR-чид л хэдэн төгрөг цалин аваад л том том мөнгө аваад л алга болоод л тэгээд л Монголын ард түмэн 70-аараа тавиулснаа гаслаад л дуусаж байна. Орано дээр ингээд та нарын яриад байгаа PR-даад байгаа гоё юм чинь хэдэн жилийн дараа баахан хор тариад Казакстаны тэр унтуулдаг тосгон шиг болчихвол хэн хариуцлага үүрэх вэ? Хариуцлага нь Монголын ард түмний өмнө хариуцах хүн бий юу. Эсвэл ингээд л Оюу Толгой шиг гаслаад л хэдэн PR чид хагартлаа баяжаад дуусах уу? Ийм 3 асуултад надад хариулт өгөөч ээ.

4 номер, дараа нь 5 номер, дараа нь 6.

**Л.Балчинлувсан:** Эдийн засаг хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого зохицуулалтын газрын дарга Балчинлувсан. Ганбаатар даргын асуултад хариулъя. Тийм энэ 14 мега төслүүд та ч сая үгэндээ хэлж байна. Зарим нь хаалттай мэдээллүүд байдаг. Ихэнх мэдээллүүдийг нээлттэй байлгах үүднээс бид нар бусад байгууллагуудтай хамтарч ажиллаж байгаа. Удахгүй dashboard.gov.mn гээд дата мэдээллийн нэгдсэн системээр энэ мэдээллүүдээ бид нар апдэйт хийгдэж байгаа. Мөн дээрээс нь АТГ-аас зөвлөмж ирүүлсэн. Энэ Аж үйлдвэржилтийн байнгын хорооноос очсон саналын дагуу гэж ойлгосон. Бид нар нээлттэй мэдээллүүдийг тавихаар төслийн нэгжүүд болон яамдуудтайгаа зөвшилцөөд нээлттэй болох бүх мэдээллүүдийг тавьж байгаа.

Гаднын хөрөнгө оруулагчдад бид нар хамгийн гол асуудал нь 14 мега төсөл бол бид нар өөрсдийн хүчээр хийх боломж хомс учраас хөрөнгө оруулагчдад мэдээллийг нээлттэй илүү их боломжит хувилбаруудаар өгөхөөр ажиллаж байгаа юм. Энэ хүрээндээ бид нар энд тэнд явж байгаа. Хамгийн сүүлд болсон Лондонд болсон хөрөнгө оруулагчдын уулзалт дээр 14 мега төслүүдийнхээ мэдээллүүдийг өгсөн. Энэ хүрээндээ бас олон улсын байгууллагууд нээлттэй байж болох мэдээллүүдийг авч байгаа. Ингээд таны зөвлөмж болон гишүүдийнхээ зөвлөсний дагуу бид нар илүү нээлттэй мэдээллүүд энэ 5 сарын дундуур гэхэд төгсгөл гэхэд нээлттэй болчих байх аа. Тэгээд эргээд танд илүү мэдээллийг өгье өө.

**С.Ганбаатар:** Энэ дээр олон улсад энэ энэ Элчин сайдуудаас хэд хэдэн удаа асуусан шүү. Тэрийг та нар минь ажилдаа бодолцоорой. Тэгээд манайд өгөөгүй байна л гэж бараг Элчин сайдууд боддог юм байна лээ шүү. Бусдад нь өгөөд гэж тэрийгээ нягтлаарай.

6 номер хариулт өгье.

**Ч.Хишигдалай:** Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны БХЗГ-ын дарга. Газрын тос боловсруулах үйлдвэр бол 2, 3 Засгийн газар дамжаад хэрэгжиж буй төсөл өө. Мэдээж томоохон төслүүдийн хувьд бол хойш урагшаа цаг хугацаа төсөв мөнгө нэмэгдэх зэрэг маш олон асуудал тулгардгийг бид биеэрээ туулаад мэдрээд явж байна аа. Газрын тос боловсруулах үйлдвэр ТӨК

Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан Эрдэнэс Монгол компанийн харьяа байгууллага. Тус компани бол өөрийн гэсэн захиралтай. Харьяалах ТУЗ-тэй. Ажил хариуцсан хүмүүс байгаа. Тэгэхээр хууль, тогтоомжийн дагуу тухайн цаг үедээ хариуцлагаа хүлээгээд явах байх аа.

**С.Ганбаатар:** Дахиад хэл дээ хэн хариуцна гэнэ ээ. 6 номерын микрофонд хариулт өгье.

**Ч.Хишигдалай:** Газрын тос боловсруулах үйлдвэр ТӨК нь Эрдэнэс Монгол компанийн харьяа компани. Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан компани ТУЗ-тэй хариуцсан албан тушаалтнуудтай ийм компани байгаа. Энэ 2.2 тэрбум долларын луйвар болоод дуусвал хариуцлагыг нь одоо ахалж байгаа хүн нь хэн байдаг юм?

**С.Ганбаатар:** Нэрийг нь хэл дээ. Захирал Алтанцэцэг. Тэгээд өөр удирдах зөвлөл нь.

**Ч.Хишигдалай:** Гэрлээ ТУЗ-ийн дарга гэж.

**С.Ганбаатар:** Ингээд ямар ч байсан луйвар болно гэж хэлээд байхад тоохгүй яваад байхад хариуцах хүн нь Алтанцэцэг, Гэрлээ 2 юм байна гэдгийг Монголын ард түмэн сонсож авлаа. Сайд нар маань Засгийн газар хариуцлага үүрэхгүй юм байна шүү дээ. Би маш сайхан ойлголт авлаа.

6 номер нэмж тодруулж хариулах гэж байна уу үгүй юу 6 номер. Та тодруулах гэж байна уу, үгүй юу? 7 номер.

**Д.Далайжаргал:** Хөрөнгө оруулалтын гэрээгээр бид нар ярьсан юм. Байгаль орчинд аливаа хохирол учруулбал хөрөнгө оруулагч тал буюу Францын төр Орано групп хариуцна гэдгийг тусгасан байгаа. Та тэр нөгөө тендерийн хувьд бол хамтарсан Бадрах Энержи компани дээр бүх олон улсын тендерийн мэдээллүүд нээлттэй байгаа. Тэндээс ороод авч болно. Хүссэн хүн очоод Бадрах Энержи компани дээр очвол ямар ч мэдээллүүдийг шууд өгч байгаа шүү. Тэр байгаль орчны юун дээр бол тэр Казакстан тэр гэдэг бол ташаа буруу мэдээлэл шүү. Тийм юм байхгүй ээ.

Бид нар 2021 оноос 2022 оны хугацаанд туршилтын үйлдвэр жил 6 сар хийхдээ яг байгаль орчинд гарч байгаа аливаа эрсдэлүүдийг бүгдийг нь тооцоод эрсдэл байхгүй юм байна, ТЭЗҮ яг тэр төсөл ашигтай гарах юм гэж үзсэн учраас бид нар Уул уурхайн яаманд танилцуулаад тэр төслийн хөрөнгө оруулалтын гэрээний ажилд орсон юм аа.

**С.Ганбаатар:** Ойлголоо тэгээд сайхан хариулт байна. Тэгэхлээр Орано бол одоо маш цэвэрхэн сайхан ашигтай Монголчуудад гээд л хариулаад байгаа. Оюу Толгой дээр яг тэгж байсан. Өдөр болгон 1 сая доллар орж ирнэ ээ. Газрын гай Ганбаатар минь чи аятайхан байгаач ээ л гэж дандаа харааж байсан. Тэгээд одоо тийм биш болчихсон. Энэн шиг юм болбол Орано хариуцна гэж ойлгож байгаа. Яг хариуцлагаа яаж үүрэх юм бол. 7 номерт хариулт өгье.

**Д.Далайжаргал:** Уран олборлодог процесс сүүлийн 60 жил явсан. Газар доор уусган олборлодог процесс дээр ямар нэгэн байгальд өрнөсөн тийм ийм зүйл

гараагүй ээ. Хэрвээ ийм юм гарвал энийг байгаль орчны нөхөн сэргээлт 10 жил байгаа. Гэхдээ бид нар бол энэ олборлох процесс нь өөрөө ийм эрсдэлүүд гарахгүй. Харин зүгээр техник технологийн хувьд бид нар маш олон улсын эрчим хүчний агентлаг, магитагийн хатуу хяналтын дор явна. 2 жил тутам хяналтыг хэрэгжүүлнэ гэж явж байгаа.

**С.Ганбаатар:** Би миний асуулт ярьж байгаа нь энэ ухаантай царайтай гоё юмнууд чинь худлаа байгаа тохиолдолд хэн хариуцлага үүрэх юм бэ гэсэн Орано хариуцлага үүрнэ ээ гэсэн. Орано яг яаж хариуцлага үүрэх юм бэ гэдэг дээр надад хариулт авсангүй. 2 өдрийн дотор бичгээр ирүүлнэ ээ гэж би ойлгож байна шүү. Протоколд бичигдэж байгаа. Ингээд маш сайхан сайхан мэдээллүүдийг авлаа дотор минь уужирлаа. Тэгээд Гэрлээ гэдэг нэртэй болж авлаа. Аятайхан л юм болж байна.

Тэгэхээр үг хэлнэ гишүүд үг хэлээд дараад нь энэ ажлын хэсгээ батална аа. Гишүүд маань ирцээ хангаарай. Үүрийнтуяа гишүүн Монголыг тэжээж байгаа хамгийн том төслийн удирдаж зохион байгуулж явсан хүний хувьд бол одоо энэ мега төслүүд дээр зүгээр л бид эзэн биегүй ингээд хаяж болохгүй. Араас нь явж байгаа нь цэвэр бид нар засаж залруулж сайжруулж үр дүн гаргая л гэж ганцхан бодолтой байгаа. Мега төслүүдийг улс төржүүлж болохгүй. Тэгэхдээ мэдээжээр унахаар дампуурахаар юмыг нь урьдчилж хэлж засаж залруулах гэж л ярьж байгаа юм шүү. Ингээд гишүүд маань үг хэлэх гишүүд байна уу байвал алга байна.

Үүрийнтуяа гишүүн үг хэлэх юм байна. Замира гишүүнээр тасаллаа. Ингээд Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн үг хэлнэ ээ.

**П.Мөнхтулга:** Мега төслүүд урагшлах ёстой. Бид нар тэгэхдээ 14 гэдэг тоогоор хязгаарлачхаад ингээд нэг хажуугаар боломж гараад ирэхлээр өө бид нар 14-ийг хийнэ ээ л гээд яваад байж болохгүй ээ. Ер нь цаг хугацаа гэдэг хамгийн үнэтэй капитал. Тэгэхээр бид нар энэ цаг хугацааг ашиглаад явуулах ёстой мега төслүүд байвал бүгдийг нь л явуулах ёстой, 15 байна уу, 21 байна уу? Боломж гарвал бүгдийг нь л явуулж байх ёстой. Яах гэж хамтарсан юм, хөгжих гэж л хамтарсан шүү дээ.

Тэгэхээр энэ 14-өөсөө дахиад одоо Их Хурлын гишүүдэд байгаа санал. Энэ Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр гарч байгаа энэ ажлын хэсэгтэй хамтарч ажиллах нь зүй ёсны хэрэг ээ. Манай Засгийн газарт хүн дутаж байгаа. Их Хурлын гишүүд нэмэр болно. Энд 14 мега төслийг эсэргүүцээд ч юм уу ингэж байгаа хүмүүс байхгүй. Та бүхнийг эрсдэлээс хамгаалах гэж байгаа бас. Тэгэхээр энэ төслийн ажлын хэсэгт орох саналтай байгаа. Тэгээд цаашдаа би түрүүн асуусан асуулт дээрээ бататгаад үг хэлчихье. Манай эдийн засгийн эргэлтийн 90 хувь нь авто замаар явж байгаа шүү. Төмөр замыг үгүйсгээгүй тэгэхдээ авто замын төслүүд дээрээ явах ёстой. Манай ДНБ-ий дөнгөж зургаахан хувь дээр авто замын нөлөө байна. Зүй ёс, эдийн засгийн онолынхоо хувьд бид нар энийг 15 хувьд хүргэх ёстой. Тэгж байж бид нарын хүнээр болон судсаар нь цус урсаж эхэлнэ ээ. Одоо манай эдийн засгийн эргэлт яг ингээд цус нь өтгөрчихсөн бөглөрөөд харвах гэж байгаа хүний нөхцөл байдал дээр байгаа. Бид нар экспортын бүтээгдэхүүнүүдээ гаргаж болно оо. Бид нар гаднаас хөрөнгө оруулалтууд татаж болно оо. Энийгээ дотооддоо шингээхдээ ажлын байраа бий болгохдоо энэ өргөн уудам нутагт тархан суурьшчихсан байгаа энэ иргэддээ эдийн засгийн үр өгөөжийг нь хүргэх зам бол тэр судас нь бол ерөөсөө авто зам. Тийм болохоор манай Эдийн засгийн хөгжлийн яамныхан 14 мега төсөл дотор чинь авто замын төсөл нэг ч алга байгаа. Тэгэхээр

15, 20 байна уу энэ авто замын төслийг заавал оруулж ирэх ёстой. Мега төслийг зөвхөн 14-өөр хязгаарлаж болохгүй ээ гэдэг ийм үг хэлмээр байна аа. Тэгээд ажлын хэсэгт орох саналаа Байнгын хорооны даргад давхар уламжилчихъя аа. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Бадамсүрэн гишүүн саналаа хэлнэ.

**М.Бадамсүрэн:** Би санал хэлэхгүй байя гэж бодсон. Тэгээд зарим энэ асуулт санал өрнөж байгаатай холбоотой хэлье ээ гэж бодлоо. Ер нь нөгөө эхлээд ингээд бүх зүйлд яг 100 хувь итгэл үнэмшилтэй биш бол энэ аймаар гоё болно гэж ер нь ярихгүй байвал зүгээр дээ гэдгийг би зөвлөх гээд байгаа юм. Тэгэхгүй бол ингээд өрнөж байгаа зүйлийг хараад байхад сэтгэлийн хөөрлөөр юм уу эсвэл нэг дарга нь үүрэг өгвөл юм уу гээд аймаар гоё яриад аягүй өндөр хүлээлт үүсгээд тэгээд нөгөөдөх нь хэрэгжилтийн шатдаа асуудал гарна. Ер нь юмыг гүйцэтгэнэ гэдэг бол аягүй хүнд шүү дээ. Ярих бол амархан хийх үнэхээр хэцүү.

Яагаад гэвэл амьдралын явцад олон саад бэрхшээл зөндөө гардаг. Тийм учраас та бүхнийг энэ том төслүүдийг гардаж хариуцаж хийж байгаа голлох албан тушаалтнуудын хувьд энэ зүйл дээр их бодитой, судалгаа тооцоотой хандаж, энэ зүйлийг бодит ажил хэрэг болгохын төлөө нэлээн хичээж ажиллах хэрэгтэй гэдгийг л би хэлье ээ гэж бодож байна. Ер нь олон удаагийн хурал дээр ингээд хараад л байгаа. Тэгээд ялангуяа энэ Мон-Атом гээд компанийн захирал бол маш их итгэл төгс ярьж байгаа шүү. Та ер нь энэ технологи сонголт гэдэг бол өөрөө том асуудал. Ялангуяа Монгол орны хувьд. Олон улсад өндөр технологи хэрэгжүүлж байна. Байгаль орчноо дээдэлж байна. Арай өртөг нь өндөр ч гэсэн сонгохдоо илүү байгальд хал багатай технологийг сонгож байгаа. Тэгээд энэ чиглэл рүүгээ анхаарч гол бодлогоо энэ зүйл дээрээ чиглүүлж явахгүй бол та бүхэн гадаад оронд очоод ингээд туршлага үздэг байх. Та нарт гоёйг л харуулж байгаа. Тэр хөшигний цаана байгаа асуудалтай зүйлүүдийг та нар үзэхгүй ирж байгаа.

Нөгөө дарга нар очихоор нэг гоё юмаа харуулаад яг асуудалтай юм харуулахгүй байна гээд ингээд шүүмжлэл гардаг. Тэрэнтэй л адилхан. Тийм учраас энэ зүйл дээр анхаарч явахгүй бол тэгээд л одоо нэг Их Хурлын гишүүд чинь бол ингээд нэг талдаа сонгогчдоосоо захиа даалгавар авч тэднийг төлөөлж байгаа субъект шүү дээ. Үндсэн хуульд заасан албан тушаалтнууд байхгүй юу. Тэгээд энэ зүйл дээр анхаарахгүй бол ингээд л нэг юм ярихаар хэлэхээр тэгээд л нэг инээсэн үл тоосон байдалтай, өөрийнхөө дүгнэлтийг туйлын зөв гээд бодчихсон тэгээд ийм байдалтай явахад хүнд шүү дээ.

Тийм учраас энэ зүйл дээрээ та бүхнийг тийм хянамгай хандаж, бодитой зөв судалгаа тооцоотой асуудалд хандаж яваарай л гэдгээ хэлж байгаа юм. Тэгэхгүй бол цаг хугацаа үнэний шалгуур байдаг. Тэгээд 1 л өдөр энэ зүйл дээр хэн ямар байр суурьтай байсан юу илэрхийлж байсан гэдэг бол тэгээд л ил тод болдог шүү дээ.

Ялангуяа энэ газрын хэвлийн баялаг ашигтай холбоотой асуудал өөрөө их бүх л улс оронд асуудалтай тулгардаг ийм л зүйл шүү дээ. Тэгээд энийг яаж зөв аргаар явах юм, яаж зөв технологи сонгох юм гэдэг зүйлийг хамгийн сайн бодох хэрэгтэй, 1 дүгээрт.

Хоёрдугаарт нь зарим гишүүд асууж байна. Тэр төрийн өмч зарим үйлдвэрүүдтэй холбоотой. Ер нь мэргэжлийн байгууллагууд та бүхэн ямар зүйл нь



яг стратегийн яг ямар салбар үйлдвэр нь төрдөө байх юм, ямрыг нь хувьчлах юм гэдгийг та бүхэн санал оруулах хэрэгтэй гэж би бол та бүхэнд үнэхээр хэлье гэж бодож байгаа юм. Тэгэхгүй бол энэ маргаантай асуудлууд чинь дуусахгүй. Яг ажлыг гардаж хийж байгаа хүмүүс илүү юунд болж байна болохгүй байна гэдгийг практик амьдрал дээр сайн мэддэг шүү дээ.

Тийм учраас энэ саналуудаа оруулж ирж ингэж ажил хэрэгч байдлаар Байнгын хороод дээр ажиллавал их үр дүнтэй байх л гэж бодож байна. Тэгээд энийг та бүхэн анхаараарай гэдгийг хэлье.

Баярлалаа.

**С.Ганбаатар:** Замира гишүүн саналаа хэлье.

**С.Замира:** Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Энэ 14 мегагаас л 126 гишүүн ямар ч хаалтгүйгээр батлаад өгсөн. Тэгээд засаг төрд хамтарсан 3 намын нэг хийх гээд бараг илүү ирж байгаа гээд бодож байна. Тийм учраас энэ чинь нэг тоглоом тохуу болох юм биш. Одоо дээд шатандаа төр засаг том юм хийе ээ гээд эдийн засгаа хөгжүүлэе ээ. Ард түмний энэ ядуурлаас гаргая гээд зүтгээд байдаг. Тэгсэн чинь энэ хэрэгжүүлэх шатан дээр дундаж ша, доод шатан дээрээ бүх юм унадаг. Өнөөдөр энэ та нарын байгаа байдал яг тэрийг нотолж байна. Ямар ч хариуцлага байхгүй, олигтойхон хариу өгч чадахгүй. Зарим нэг нь мэдэх ёстой юмаа мэдэхгүй шоолоод инээгээд Их Хурлын гишүүд яг суугаад байдаг. Энийг хэлэхгүй бол болохгүй, 1 дүгээрт ийм юм хэлмээр байна.

Хоёрдугаарт бол энэ нэг төслүүдийг аль болох хөрөнгө оруулалт татах замаар хэрэгжвэл зүгээр юм болов уу гээд бодож байна. Яагаад гэвэл зээл авч үйлдвэр барина гэдэг чинь маш хүнд асуудал шүү дээ. Эхнийх нь яах вэ тэр юуны Энэтхэгийн төсөл нь явсан байгаа. Тэгэхдээ дараа дараачийнхаа юм юман дээр анхаарах нь зүйтэй болов уу.

Эхний ээлжид энэ дэд бүтцээ шийдэж авбал зүгээр болов уу гээд бодож байна. Энэ төслүүдийг хэрэгжүүлэхийн төлөө бас давхар сая гишүүд ярьж байна. Алтны үнэ маш их өссөн байгаа. Зэс бас үнэ нэмэгдсэн байгаа. Тийм учраас алт хөтөлбөр гээд өнөөдөр Засгийн газар шийдвэр гаргачихсан байна. Тэрэнд их баяртай байна.

Тийм учраас эхний ээлжид энэ алтаа сайн явуулж тэрүүгээрээ өөрснөө санхүүжилт хийж энэ үйлдвэржүүлэлтийн бүх юмыг дэд бүтцийг энүүгээр уг нь шийдэх нь зүйтэй болов уу гээд бодож байна. Аль болох гадаадаас өр зээл авахгүй байх, өр зээлд унахгүй байхыг бодох хэрэгтэй. Бас нэг хэлэх юм бол Оюу Толгой гээд өр нь манай Монгол орныг нэлээд толгой өргүүлсэн эхний хийсэн гэрээ хэлэлцээр нь тэр чигээрээ алдагдалдаа. Монгол оронд өр зээлд унаад байгаа. Тэгсэн чинь сая юу гэнэ вэ сая Оюу Толгойгоос дахиад санхүүжилт авч байгаа гэнэ үү? Тэр санхүүжилт нь ямар учиртай санхүүжилт вэ? Тэр нь ядахдаа хийгдсэн гэрээ байна уу? Дараа нь одоо тэр чинь нэг тэрбум төгрөг өгчхөөд өө энэ чинь хүүтэй гээд дахиад хэдэн жилийн дараа ч юм уу хэдэн сарын дараа хэдүүлээ дахиад нэг хүү тосоод сууж байх юм биш үү? Ийм юмнууддаа анхаарал хандуулж бодитой юм хийвэл сайн л байна сайд нь байхгүй байна. Тэгэхдээ яах вэ манай Байнгын хорооны дарга ингээд өнөөдөр ингээд энэ том 14 мянга төслийг хөдөлгөө гээд бид

хэд та хэдтэй ингээд уулзаж байгаа. Үр дүн гаргах болов уу гээд бодож байна залуучуудаа идэвхтэй ажиллаарай.

**С.Ганбаатар:** Сонгобайн Замира гишүүн маш чухал үг хэллээ. Баярлалаа. Ингээд Жаргалсайханы Золжаргал гишүүнийг үгэнд оруулаарай. Ингээд Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн үг хэлнэ ээ.

**Д.Үүрийнтуяа:** Өнөөдөр бид Эдийн засгийн хөгжлийн яамны хувьд мэдээлэл сонсож байгаа шүү дээ. Гол бодлогын яам. Ялангуяа хөгжлийн гол стратегиудыг барьж, төлөвлөж, эрэмбэлж хэзээ юу хийх ёстой вэ? Аль төслийг эхэлж оруулах ёстой вэ? Тэрний үр өгөөжөөр дараагийн ямар төслийг хөдөлгөх ёстой вэ? Үндсэндээ яамдыг чиглүүлж байх ёстой чиг үүрэгтэй яам ийм хэмжээнд ажлын гүйцэтгэл тайлагнан сууж байгаад харамсалтай байна. Албан бичиг хугацаандаа өгөхгүй бол Их Хурлын гишүүний асуултад хугацаандаа хариулахгүй байх техникийн алдаа болдог юм байна гэж танай яамны ажил ингэж явдаг болжээ л гэж ойлголоо. Техникийн алдаа байсан юм байна. Би тодорхой цаг хугацаатай, он сартай мэдээллүүд дээр би асуулт асууж байгаа шүү. Эдийн засгийн хөгжлийн яамны гол бодлого барьж байгаа газрын дарга төслүүдийнхээ талаар ойлголтгүй байгаад харамсалтай байна. Уул уурхайн яам хариулж байх жишээтэй.

Үйлдвэр технологийн паркийн төслийн нэгжээс ярьж байх жишээтэй. Өнөөдөр энэ зэс боловсруулах цогцолбор дээр чинь компани байгуулагдчихаад байгааг мэдэж байгаа юу, үгүй юу. Ийм учраас надад тодорхой хэдэн санал байна.

Нэгдүгээрт би энэ хугацаандаа аваагүй, ирсэн нэр зүүсэн бичгийнхээ хариуг тодорхой авмаар байна. Эдийн засгийн тооцоо судалгаатай нь авмаар байна. Зураг төсөв ТЭЗҮ-тэй нь авмаар байна. Өнөөдөр тавьсан асуултууддаа тодорхой хариултуудыг авсангүй.

Тийм учраас таны хариулж байгаа тэр эдийн засгийн хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын өгөөж, эдийн засгийн үр өгөөжийн тооцоо гэдэг дээр би хариултаа авч чадсангүй. Тийм учраас энэ бүх мэдээллүүд асуултууд дээрээ би тодорхой хариултууддаа Дэгийн тухай хуулийн 9.16-гийн дагуу энэ хугацаанд заасан хугацааны дагуу би авмаар байна.

Энэ хурлаар хэлэлцэгдсэн яригдсан асуудлаа протоколд хяналт тавьж өгөхийг Байнгын хорооны даргаас хүсэж байна. Гишүүдийн хэлж байгаа үг, бичсэн бичигт хариу өгдөггүй газар юм байна лээ. Ер нь цаашдаа ажлын хэсэг байгуулагдаад энэ төсөл бүрээрээ асуудлаа тодорхой сонсмоор байна аа. Ийм ерөнхий мэдээлэл дээр бид нар ажил төлөвлөж явж чадахгүй.

Тийм учраас 14 мега төсөл бүрээрээ бүх асуудлыг тодорхой болгоод, дараагийн удаа дахин, төсөл бүрээр нь явцыг сонсьё.

Аж үйлдвэржилтийн мега төслүүдийн төсөл бүрээр нь эрчим хүчний эх үүсвэр хангамжийн асуудлыг тодорхой болгож танилцуулмаар байна. Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн түшиглэсэн гангийн цогцолборын асуудал. Өнөөдөр эрчим хүчний асуудал нь шийдэгдээгүй л байх ёстой. Гэтэл бид нар удахгүй орох юм шиг юм яриад суугаад байгаа юм. Зэс боловсруулах үйлдвэр зэсийн үйлдвэр гэж яриад байгаа юм. Зэсийн баяжмал хайлах, боловсруулах үйлдвэр. Энэ үйлдвэрийн ТЭЗҮ-д яаралтай тодотголыг хийх хэрэгтэй байна аа. Яам хариуцсан

чиг үүргийнхээ хүрээнд ажлаа шуурхайлаач ээ. Эдийн засгийн хөгжлийн яам энд их хяналтаа тавьж ажиллаач ээ.

Ингээд энэ дараа нь стратегийн хөрөнгө оруулагчийг татах санхүүжилтийн механизм ашиглах ажлыг нь эзэнтэй болгож хугацаатай үүрэг даалгавар өгч энэнийхээ хэрэгжилтийг хянаж ажиллаач ээ. Бид нар бодлого ярина гээд суугаад баймааргүй байна шүү дээ. Хэн хийх юм. Тэгээд энэ эдийн засгийн том төслүүд үр өгөөжөө өгөх төслүүдээ хурдан хугацаанд, богино хугацаанд оруулж байж эндээс орж ирж байгаа үр өгөөжөөр нь дараа дараагийн төслүүдийн санхүүжилт явах ёстой шүү.

Баялгийн солилцоо валью эксченжийн асуудал өнөөдөр хууль болоод орж ирж байхад Эдийн засгийн хөгжлийн яам энэ талаар мэдээлэлгүй байна гээд сууж байж болохгүй шүү дээ. Юу гэсэн үг юм бэ? Эдийн засгийн хөгжлийн яамны дарга нарын байр суурь.

**С.Ганбаатар:** Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт үг хэлье.

**Ж.Золжаргал:** Мега төсөл гэнэ үү өөрөөр нэрлэнэ үү? Улсын эдийн засгийг чухал хөгжүүлэх хөдөлгөх гэж байгаа том төслүүд гэдгээрээ ач холбогдолтой. Тэгээд зарим төслүүд маань эхэлчихсэн явж байгаа. Гэхдээ мега төсөл гэдэг мега гэдэг үг өөрөө PR-ын зорилгоор орж ирсэн үг. Их л том нийгэм эдийн засгийн далайцтай гэсэн утгатай. Тэгээд тэрүүгээрээ маш их өөдрөгөөр PR-т бол ёстой бужигнуулаад өгнө гэдэг байдлаар олон төсөл анх туг болгож барьж орж ирсэн. Өнөөдрийн дэлхий ертөнц болоод Монголын эдийн засгийн байдал өөр болчихсон. Эрсдэлтэй зүйл маш их байна. Тийм учраас шийдсэн боломжтой санхүү нь тодорхой төслүүд дээрээ төвлөрөөд бусдыг нь эрэмбэлээд хойшлуулахыг нь хойшлуулаад ингээд явахгүй бол эцсийн дүндээ мега төсөл маань эдийн засгаа аврах биш эдийн засгаа хөмрөх юм болчих вий.

Хоёрт нь хэлэх зүйл мега төсөл аль нэг төсөл тодорхой жишээ аваад ч яах вэ хэд хэдэн төслүүд байна. Тэд нарын хооронд, тэд нарын хүрээнд энэ төсөл ингээд хэрэгжсэнээрээ одоо жишээ нь төмөр замын төсөл ярьж байгаа бол хэрэгжсэнээрээ мод тарина ч гэдэг юм уу, ус усны хоолой барина ч гэдэг юм уу ингээд хаа хамаагүй юманд бид нар анхаарна дашрамд гэдэг юм. Энэ бол нөгөө чихрийн цаас үзүүлэх технологи. Бас л PR хүмүүсийн дэмжлэгийг авах гээд яг төсөлтэй нь холбоогүй юмнуудыг ингээд хамруулаад нэг оруулсан болоод бичээд тайвшруулах байдлаар эргээд нөгөөхөө хийхдээ хүрэх юм бол нэмэлт зардал гарна. Үр ашиггүй юм болно. Ер нь хэрэгжихгүй. Зүгээр нэг ингээд чихрийн цаас үзүүлж байгаа байдал. Яг иймэрхүү байдлаар өө ерөөсөө л ингээд л бүх юмнуудаа ер нь ингээд оруулаад байя. Толгойд орсон болгоноо ингээд байя. Энийг бол ерөнхийдөө агуулгаар нь ингэсхийгээд оруулчихвал энэ гишүүд дэмжчих юм шиг байна гээд буцаагаад нөгөөдхөөрөө өөрчлөлт оруулаад ингэж явсаар байгаад энэ чинь нэг ийм фокус нь алдагдаад сарниад нэг түмэн юм болчихоод байна аа.

Тэгэхээр түмэн юмыг Монголчууд дийлэхгүй, манай эдийн засаг ч дийлэхгүй дэлхий ертөнц ч эвгүй болчихсон байна. Тэгээд энийг аргалах гэж орж ирж байгаа нь тэр бартер байхгүй юу. Баялаг солилцох энэ тэр гээд гоё нэрлээд байгаа болохоос биш бартер. Бартер бол хямд байдаг. Энэ дээрээ бид нар Засгийн газар нь ч тэр гишүүд нь ч тэр анхаарахгүй бол за яах вэ угаасаа явах нь тодорхой юм

чинь нэг юм наачихъя гээд ингээд нус наагаад байх юм бол сүүлдээ өөрсдөө дийлэхээ байна шүү. Үүнийг хэлье баярлалаа.

**С.Ганбаатар:** Ингээд Жаргалсайханы Золжаргал гишүүн үг хэллээ. Миний хамт олон бүгдээрээ л Монголдоо хайртай Монголын төлөө явж байгаа мэдэж байгаа. Тэгээд би хоёрхон л үг хэлчихье дээ товчхон. 14 мега төсөл гэдэг бол ер нь яг Засгийн газрын энэ чадавх энэ байж байгаа царайнд нь арай л ахдаж байгаа юм даа. Залгих хэмжээнээсээ илүү л зажлах гэж оролдох л юм бол тэгээд л хахаж үхнэ шүү дээ. Бид яг чадлаасаа. Одоо ингээд нөхцөл байдлыг харахаар ингээд л 14 мега төсөл ямар хүчтэй эхэллээ. Тэгээд л дуу дуугүй авалцаж чимээгүй болж эхэлж байгаа. Бүх талаараа хүчтэй байх гэж оролдоно гэдэг бол бүх талаараа сулын шинж байдаг юм аа. Стратегийн том хууль байна.

Тэгэхээр энэ мөрөөдлийн жагсаалт энэ бодитой болоосой гэдэг үүднээсээ л энэ гишүүд ингэж ярьж байгаа юм шүү. Улсын Их Хурлын гишүүдийг Монголын ард түмэн сонгодог. Ерөнхий сайд, сайд, энэ агентлагийн дарга нар та нарыг нэгийг нь ч ард түмэн сонгодоггүй. Дараа нь Монголын ард түмэн энэ хэрэгжсэнгүй ээ, уран чинь хоргүй гэсэн хортой байна эсвэл юу гэдэг юм тэр газрын тосны үйлдвэр чинь нохойн замаар орчихлоо гэх юм бол бидэнтэй л ганцхан хариуцлага тооцдог.

Ингээд Улсын Их Хурал баталсан хуулийнхаа хэрэгжилтийг хянах утгаараа өнөөдөр араас чинь бид нар явна. Сонгогчдоо бид тайлагнаж ярих үүднээсээ тэгээд ард түмний өмнө хариуцлага үүрдгийнхээ хувьд та бүхэн маань бидэнтэй ойрхон дотно ажиллаарай. Авч байгаа цалингийнхаа төлөө эх орныхоо төлөө гишүүдээс түрүүн нэг чухал саналууд гарч байна. Хуулийн хугацаа байгаа. 14 хоног байна уу, 30 хоногт. Хариулт ирэхгүй бол гишүүдийг үл хүндэлж байгаа биш ард түмнийг ийм тохиолдолд гишүүд болон хурлын зохион байгуулалтаар хангаж байгаагийн хувьд Байнгын хорооны даргын хувьд надаар дамжуулбал бүр сайн. Шууд Цэцэд өгнө гэдгээ та нар өөрсдөө хариуцлагатайгаар хийхгүй нялцганаад л байвал нялцганаад л байна шүү. Ингээд бидэнд мэдээлэл өгч оюуны минь сүвийг нээтэл ярьж өгсөн нийт ажлын хэсгийн хамт олонд баярлалаа.

Сайд нартаа онцгой анхааруулж хэлээрэй.

Хэдүүлээ энэ ажлыг үр дүнтэй ажил болгоно оо. Ингээд ажлын хэсэгт баярлалаа.

Мэдээлэл авч дууслаа.

17.58 цагт

Ингээд дараагийн хэлэлцэх асуудал маш хурдтай явна. Үүний дараа Замира гишүүний Ашигт малтмалын тухай хуулийн 42-ын ажлын хэсэг хуралдах юм байна шүү манай өрөөнд хуралдах байх. Ингээд мэдээллийн чанартай зүйл өгчихье.

Ингээд ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг боловсруулж та бүхэнд тараасан байгаа. Та бүхэнд танилцуулъя.

Хэлэлцэх асуудлынхаа 2-т орёё.

Ингээд ингээд 2 дахь хэлэлцэх асуудалдаа орж байна. **Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол.**

Ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.4 дэх заалт Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мега төслүүдийн хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан дээрх мега төслүүдийн хэрэгжилтийн явцыг судлах үйл ажиллагааг эрчимжүүлэх бодлогын дэмжлэг үзүүлэх хүрээнд холбогдох санал дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай гэсэн байна.

Ажлын хэсгийг ахалж Д.Үүрийнтуяа Улсын Их Хурлын гишүүн, Пүрэвбаатарын Мөнхтулга Улсын Их Хурлын гишүүн, Болдын Уянга Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Сонгобайн Замира, Доржзодовын Энхтуяа, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, М.Энхцэцэг, Буяагийн Тулга гэсэн ажлын хэсэг байна. Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох салбарын мэргэжилтэн шинжээчдийг татан оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй гэсэн ийм ажлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар гэсэн ийм тогтоолын төслийг та бүхэнд танилцууллаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт болон саналтай гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Буяагийн Тулга гишүүнээр тасаллаа. Буяагийн Тулга гишүүний сайдын микрофоныг нээж өгье.

**Б.Тулга:** Тийм гишүүдийн тоо бас нэлээн байгаа учраас би нэрээ татчихъя. Очирбат гишүүн оръё гэсэн санал гаргаж байгаа шүү гол зүйл нь.

**С.Ганбаатар:** Тогтоолын төсөлд Буяагийн Тулга сайд нэрээ татаад Ганбатын Очирбат гишүүн нэрээ оруулж байна.

Ингээд тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Микрофон. Заримынх нь ажилласангүй шүү. Үүрийнтуяа гишүүн бол дэмжсэн санал өгсөн. Ингээд нийт гишүүддээ анхааруулахад гишүүд ээ анхааралтай байгаарай. Гишүүддээ анхааруулахад ажлын хэсэг байгуулагдлаа. Энэ ажлын хэсэг бол нарийн ярих юм бол бараг 14 мега төсөл дээр 14 ажлын хэсэг байгуулах хэмжээний томоохон объектой ийм ажлын хэсэг шүү. Тэгээд энэ дээр идэвхтэй чармайлттай ажиллаарай. Одоо бас мега төслүүдийн талаар туршлагатай гишүүдээрээ бүрдүүлж орууллаа.

Үүрийнтуяа гишүүн энийг ахалж ажиллаж байна. Ингээд ажлын хэсгийн хамт олондоо амжилт хүсье ээ.



Монголын ард түмэн энийг хүлээж байгаа. Ингээд өнөөдрийн хуралдааныг ингээд.

11.03 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА